



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ,
ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ТАЙЛАГНАСАН Ч
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: УВА-2025/31-19-ШТА-ГА

Улаангом хот 2025 он

Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn

Аудитын менежер М.Бат-Амгалан

Утас: 70453317 Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Авирмэд

Утас: 70453317 Цахим хаяг: avirmedb@audit.gov.mn

Аудитор Р.Аюуш

Утас: 70453317 Цахим хаяг: ayushr@audit.gov.mn

Аудитор Б.Одгэрэл

Утас: 70453317 Цахим хаяг: odgerelb@audit.gov.mn

Аудитор Т.Батсүх

Утас: 70453317 Цахим хаяг: batsukht@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт, Графикийн жагсаалт	4
Графикийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ерөнхий мэдээлэл	6
Бүлэг1 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.	7
1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.	7
1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?	7
1.1.2 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримталж хуваарилж олгосон байна.	7
1.1.3 Сангийн яамнаас 522.8 сая төгрөгөөр санхүүжилт дутуу ирснээс шалтгаалан аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваариас бууруулан олгосон байна.	8
1.1.4 Аймаг, сумдын ОНХС-д ОНХНС-аас хуваарилснаас гадна 4,574.1 сая төгрөгийг нэмж төлөвлөж гүйцэтгэлээр 4,559.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.	10
1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 2 сум иргэдээс санал аваагүй, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй төсөл, арга хэмжээг 3 сум ИТХ-аар батлуулан зарцуулсан байна.	12
1.2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Малчин, Өлгий сум нь иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан байна.	12
1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй 3 сумын 31 төсөл, арга хэмжээнээс бусад нь уялдсан байна.	13
1.2.3 Төсвийн тухай хуульд заасан шаардлага шалгуур хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.	16
1.2.4 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 75.4 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь ОНХС-ийн журам хангагдахгүй эрсдэл үүсэж байна.	17
Бүлэг2 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	21
2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Сагил сум 116.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, ОНХС-ийн хөрөнгийг бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан ч зориулалт бус зардал гарсан байна.	21
2.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Сагил сумаас бусад нь холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	21
2.1.2 ОНХС-ийн хөрөнгийг бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан ч зориулалт бус зардал гарсан байна.	26
2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх боломж байна.	29
2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүн 81.3 хувьтай байна.	29
2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц, зохих үр нөлөөтэй байна.	31

2.3	ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.	34
2.3.1	ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.	34
2.3.2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.	35
Бүлэг3	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН, ХЯНАЛТЫГ ЗОХИХ ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.	37
3.1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт зохих түвшинд хэрэгжсэн байна.	37
3.1.1	Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналтыг хэрэгжүүлсэн, харин Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.	37
3.1.2	ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнасан боловч зарим төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй, удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим хуудаст бүрэн мэдээлээгүй байна.	39
3.1.3	Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна	40
3.2	ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнасан боловч зарим төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй, удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим хуудаст бүрэн мэдээлээгүй байна.	43
3.2.1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.	43
3.2.2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 649.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.	43
3.2.3	Удирдлагын мэдээллийн системд 9 сум 204 төсөл, арга хэмжээний мэдээлэл дутуу оруулсан, аймгийн ОНХС болон 5 сум 41 төсөл, арга хэмжээний мэдээллийг огт оруулаагүй байна.	44
3.2.4	ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Бөхмөрөн, Завхан сум хугацаандаа мэдээлэл байршуулаагүй байна.	46
Дүгнэлт		48
Холбогдох байгууллагын санал		49-50
Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар		51
Зөвлөмж		52-53

Товчилсон үгийн тайлбар

ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМХТЗТ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр
АМАТЗТ	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХО	Хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
СХДАГ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЗӨСТ	Зоонозын өвчин судлалын төв
ТНХ	Түмэнд нээлтэй хязгаарынхан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ДДТ2	Дулаан дамжуулах төв
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХАА	Худалдан авах ажиллагаа
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ШГБ	Шууд гэрээ байгуулах

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2024 оны төсөвт тодотгол хийсэн дүн.	7
Хүснэгт 2. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт	8
Хүснэгт 3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	9
Хүснэгт 4. Сумдын ОНХС-д олгосон санхүүжилт	9
Хүснэгт 5. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт.....	11
Хүснэгт 6. Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Хүснэгт 7. Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо	14
Хүснэгт 8. Аймгийн ОНХС-гийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байдал.....	14
Хүснэгт 9. Аймгийн ОНХС-гийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдсан байдал	15
Хүснэгт 10. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулаагүй төсөл арга хэмжээний тоо, зөрчил гаргасан сумууд.....	15
Хүснэгт 11. Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ ОНХС-ийн журмыг 4.2-д заасан чиг үүрэг	18
Хүснэгт 12. Сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ ОНХС-ийн журмын 4.4-д заасан чиг үүрэг	19
Хүснэгт 13. Сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ ОНХС-ийн журмын 4.4-д заасан чиг үүрэгт нийцээгүй төсөл, арга хэмжээ.....	20
Хүснэгт 14. Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжсэн ажлын сонгон шалгаруулалт	23
Хүснэгт 15. Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт	26
Хүснэгт 16. Аймгийн ОНХС-аас хийгдсэн хэрэгжилт дутуу 3 төсөл, арга хэмжээ.....	30
Хүснэгт 17. Сумдын ОНХС-аас хийгдсэн хэрэгжилт дутуу 38 төсөл, арга хэмжээ	30
Хүснэгт 18. Бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээ, зорилтод түвшин	31
Хүснэгт 19. Аймаг, сумдын ОНХС-ын иргэдийн санал авсан төсөл, арга хэмжээ, төсөвт өртөг	32
Хүснэгт 20. Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний сайн жишээ.....	33
Хүснэгт 21. Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн ашиглалт	34
Хүснэгт 22. Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд ашиглагч байгууллагын зүгээс өгсөн чанарын үнэлгээ.....	35
Хүснэгт 23. Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд хийсэн хяналтын дүн.....	38
Хүснэгт 24. Аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт	40
Хүснэгт 25. Аймаг, сумдын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчил, хэрэгжилт	40
Хүснэгт 26. Аймаг, сумдын ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийн мэдээлэл.....	45

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ	18
--	----

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, А/107 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамруулсан.*

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, Худалдан авах ажиллагааны газар, ОНӨГ, ГХБХБГ, СХДАГ, баг, хорооны Засаг дарга, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Р.Аюуш, Б.Одгэрэл, Т.Батсүх нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд

хийсэн аудитаар 10 албан шаардлага, 9 зөвлөмж өгч, Үндэсний аудитын газарт 1 санал хүргүүлээ.

Сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар ОНХС-тай холбоотой илэрсэн зөрчилд 3,216.7 сая төгрөгийн 6 зөвлөмж, 2,628.8 сая төгрөгийн 10 албан шаардлага, аймгийн ОНХС-д 6,253.1 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн байна. Дээрх зөрчлүүдийг аудитын тайланд давтан тусгаагүй бөгөөд өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийн хэсэгт тусгасан болно.

Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлээр ОНХНС болон улсын төсвөөс аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 12,477.3 сая төгрөгөөр баталсан ба 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 591.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 13,069.1 сая төгрөгөөр баталсан байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 12,703.5 сая төгрөг, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 365.6 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд аймгийн хэмжээнд 568 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр ИТХ-аар баталж, 3 сум он дамжин хэрэгжсэн 4 төсөл арга хэмжээг батлуулахгүйгээр үлдэгдэл санхүүжилтийг олгосон байна. Үүнээс 12,736.3 сая төгрөгийн 460 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 2,510.0 сая төгрөгийн 41 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 3,007.4 сая төгрөгийн 71 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй буюу төсөл, арга хэмжээний хэрэгжилт 81.3 хувьтай байна.

БҮЛЭГ 1

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?

Орон нутагт хамаарахгүй.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримталж хуваарилж олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно”, 59.3.1 дэх заалтад “орон нутгийн хөгжлийн индекс”, 59.3.2 дахь заалтад “хүн амын тоо”, 59.3.3 дахь заалтад “нутаг дэвсгэрийн хэмжээ”, 59.3.5 дахь заалтад “өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ” гэж заасны дагуу ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилж олгосон байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн санд ОНХНС-аас 12,477.3 сая төгрөгийн санхүүжилт баталсныг тодотгол хийж 13,069.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна. Үүнд:

Хүснэгт 1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2024 оны төсөвт тодотгол хийсэн дүн

(сая төгрөг)

Аймаг	Итгэлцүүрээр хуваарилагдах дүн	АМХТЗТ	АМАТЗТ	Урамшуулал	Нийт
Увс	12,437.7	75.4	190.4	365.6	13,069.1

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө”, 6.2-т “Сум, дүүргийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө” гэж заасан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр
- Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр
- Тухайн орон нутгийн орлогыг дэмжих зорилгоор авах дотоод, гадаадын хандив тусламж

Дээрх журамд заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

Ингэхдээ ОНХНС-аас олгохоор баталсан санхүүжилтийг аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/04 дүгээр тогтоолоор 2024 онд аймгийн

ОНХС-д 4,738.4 сая, сумдын ОНХС-д 7,738.9 сая, нийт 12,477.3 сая төгрөгийг олгохоор анх баталсныг аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 21/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж аймгийн ОНХС-д 4,975.1 сая, сумдын ОНХС-д 8,094.0 сая, нийт 13,069.1 сая төгрөг олгохоор баталж, гүйцэтгэлээр аймгийн ОНХС-д 4,800.5 сая, сумдын ОНХС-д 7,745.8 сая, нийт 12,546.3 сая төгрөгийг олгосон байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, тогтоомжид заасны дагуу дараах байдлаар төлөвлөж бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт

(сая төгрөг)

№	Орлогын нэр төрөл	Аймаг		Сум	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	ОНХНС	4,975.1	4,800.5	8,094.0	7,745.8
2	Өмнөх оны үлдэгдэл	1,630.0		1,613.6	
3	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр			33.8	33.8
4	Олон улсын төсөл хөтөлбөрөөс олгох дэмжлэг, урамшуулал			10.0	13.2
5	Бусад орлого		21.9	385.9	482.5
6	Малын тоо толгойн албан татвар			901.5	806.5
	Нийт дүн	6,605.1	4,822.4	11,038.8	9,081.8

Эх сурвалж: Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ, сумдын Санхүүгийн алба

Хүснэгтээс харахад ОНХС-ийн эх үүсвэрт аймаг, сумдын ИТХ-аар 17,643.9 сая төгрөг төлөвлөн баталж, гүйцэтгэлээр 13,904.2 сая төгрөг олгосон байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 13,069.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөн баталж, гүйцэтгэлээр 12,546.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.1.3. Сангийн яамнаас 522.8 сая төгрөгөөр санхүүжилт дутуу ирснээс шалтгаалан аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваариас бууруулан олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна” гэж заажээ. Үүнд:

- Энэ зүйлийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээг харгалзан хуваарилах;
- Улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6-д зааснаар хуваарилах.
- Энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.

Хүснэгт 3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг

(сая төгрөг)

№	Үзүүлэлт	Нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах		Хүн амын тооноос хамаарах		Ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнээс хамаарах		Итгэлцүүрээр хуваарилагдсан нийт дүн	Урамшуулал	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	2024 онд олгохоор төлөвлөсөн санхүүжилт	2024 онд олгосон санхүүжилт
	Сумдууд	Нутаг дэвсгэрийн хэмжээ /мян.км2/	Нутаг дэвсгэрээс хамаарах хуваарилалт 34%	Хүн амын тоо	Хүн амын тооноос хамаарах хуваарилалт 33%	Ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбай	Ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнээс хамаарах хуваарилалт 33%						
1	Баруунтуруун сум	3.3	120.3	2.8	79.3	-	-	199.5	-	-	-	199.5	190.5
2	Бөхмөрөн сум	3.7	134.8	2.3	66.6	4.1	481.3	682.7	-	-	15.0	697.6	666.2
3	Давст сум	6.3	229.6	1.6	45.3	0.1	12.1	286.9	-	-	0.8	287.7	274.7
4	Завхан сум	6.8	247.8	1.9	54.5	0.4	45.9	348.3	-	-	4.3	352.6	336.7
5	Зүүнговь сум	4.0	145.8	2.9	83.3	-	-	229.0	-	-	-	229.0	218.7
6	Зүүнхангай сум	2.6	94.7	2.4	68.9	0.1	6.8	170.4	73.5	6.1	0.6	250.6	239.3
7	Малчин сум	4.0	145.8	2.5	70.9	-	-	216.7	50.1	36.7	-	303.5	289.8
8	Наранбулаг сум	5.3	193.1	4.4	125.8	9.8	1,145.5	1,464.5	-	0.3	107.0	1,571.8	1,501.0
9	Өлгий сум	2.3	83.8	2.5	71.8	-	-	155.6	-	3.9	-	159.5	152.3
10	Өмнөговь сум	3.2	116.6	4.8	137.7	0.2	25.7	280.0	73.8	14.9	2.0	370.7	370.7
11	Өндөрхангай сум	4.7	171.3	3.2	93.1	-	-	264.4	-	5.0	-	269.4	257.3
12	Сагил сум	3.8	138.5	2.5	72.4	0.2	17.9	228.7	-	-	1.7	230.4	220.0
13	Тариалан сум	3.8	138.5	4.1	118.8	2.2	255.7	513.0	52.4	1.0	17.7	584.1	557.8
14	Түргэн сум	2.3	83.8	2.1	59.9	2.3	270.2	413.9	-	0.1	24.4	438.3	418.5
15	Тэс сум	3.1	113.0	5.2	149.3	-	-	262.3	-	-	-	262.3	250.4
16	Ховд сум	3.0	109.3	2.5	73.4	0.2	20.0	202.6	55.7	-	0.6	259.0	247.3
17	Хяргас сум	3.4	123.9	2.6	73.8	1.0	112.5	310.2	-	3.6	10.5	324.3	309.7
18	Цагаанхайрхан сум	4.0	145.8	2.1	60.9	0.5	60.3	266.9	60.0	3.9	5.6	336.4	321.2
19	Улаангом	0.03	1.1	33.2	957.0	0.1	8.9	967.0	-	-	0.3	967.3	923.7
Дүн		69.6	2,537.3	85,478.0	2,462.6	21.2	2,462.7	7,462.6	365.6	75.4	190.4	8,094.0	7,745.8

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 7.2-т “Аймаг, нийслэл нь энэ аргачлалын 3.4-т зааснаас бусад хэсгийн 60 хувийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т заасны дагуу итгэлцүүрийг харгалзан сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилах бөгөөд үүнд энэ аргачлалын 7.1.1-7.1.2-т заасан орлогыг хүлээн авсан сум, дүүрэг нэгэн адил хамаарна” гэж заасны дагуу ОНХНС-аас олгосон шилжүүлгийг сумдын ОНХС-д хуваарилахдаа хүн амын тоо, ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнээс тус бүр 33 хувь, нутаг дэвсгэрийн хэмжээнээс 34 хувиар хамааруулж тооцсон байна.

Сумдад олгохоор төлөвлөсөн санхүүжилт Сангийн яамнаас 522.8 сая төгрөгөөр дутуу ирснээс шалтгаалан сум бүрд тодорхой хэмжээгээр бууруулан хуваарилж олгосон байна. Үүнээс шалтгаалан тухайн жилийн Төсвийн тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй, төлөвлөсөн ажил гүйцэт хэрэгжихгүй байх эрсдэл үүсэж байгаа тул нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

Хүснэгт 4. Сумдын ОНХС-д олгосон санхүүжилт

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ОНХНС-аас олгосон санхүүжилт			
		Батлагдсан дүн /тодотголоор/	олгосон санхүүжилт	Зөрүү	Ирсэн санхүүжилтийн хувь
1	Баруунтуруун	199.5	190.5	9	95.5
2	Бөхмөрөн	697.6	666.2	31.4	95.5
3	Давст	287.7	274.7	13	95.5
4	Завхан	352.6	336.7	15.9	95.5
5	Зүүнговь	229.1	218.7	10.4	95.5
6	Зүүнхангай	250.6	239.3	11.3	95.5
7	Малчин	303.5	289.8	13.7	95.5
8	Наранбулаг	1571.8	1501	70.8	95.5
9	Өлгий	159.5	152.3	7.2	95.5
10	Өмнөговь	370.7	370.7	0	100.0

11	Өндөрхангай	269.4	257.3	12.1	95.5
12	Сагил	230.4	220	10.4	95.5
13	Тариалан	584.1	557.8	26.3	95.5
14	Түргэн	438.3	418.5	19.8	95.5
15	Тэс	262.3	250.4	11.9	95.5
16	Ховд	258.9	247.3	11.6	95.5
17	Хяргас	324.3	309.7	14.6	95.5
18	Цагаанхайрхан	336.4	321.2	15.2	95.5
19	Улаангом	967.3	923.7	43.6	95.5
20	Увс аймаг	4975.1	4800.5	174.6	96.5
Дүн		13,069.10	12,546.30	25,615.40	95.8

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2 дахь заалтад “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.9-д “ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх суурь зардлыг тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хэмжээнээс хэтрүүлэхгүй” гэж заасныг мөрдөж ажилласан байна.

1.1.4. Аймаг, сумдын ОНХС-д ОНХНС-аас хуваарилснаас гадна 4,574.1 сая төгрөгийг нэмж төлөвлөж гүйцэтгэлээр 4,559.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “ОНХС нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заажээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;
- Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь;
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь;
- Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна;
- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж;
- Энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт.

Хүснэгт 5. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт

(сая төгрөг)

№	Сумын нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ОНХС-аас батлагдсан дүн /тодотголоор/	Дотоод гадаадын хандив, тусламж болон бусад орлого	Малын тоо толгойн татвар	Нийт
1	Аймаг	1,630.0	4,975.1			6,605.1
2	Баруунтуруун	72.3	199.5		48.0	319.8
3	Бөхмөрөн	32.8	697.6		15.2	745.6
4	Давст	127.5	287.7		20.1	435.3
5	Завхан	88.0	352.6	85.2	43.9	569.6
6	Зүүнговь	206.8	229.0		18.5	454.3
7	Зүүнхангай	19.3	250.6	56.0	40.0	365.9
8	Малчин	25.1	303.5	77.9	74.0	480.5
9	Наранбулаг	35.0	1,571.8	36.0	35.0	1,677.8
10	Өлгий	47.1	159.5		14.2	220.8
11	Өмнөговь	4.2	370.7	36.4	166.3	577.6
12	Өндөрхангай	202.9	269.4	61.7	79.3	613.4
13	Сагил	102.6	230.4		60.0	393.0
14	Тариалан	174.4	584.1		0.0	758.5
15	Түргэн	0.0	438.3		40.0	478.3
16	Тэс	223.3	262.3		80.0	565.6
17	Ховд	120.5	259.0	3.0	35.0	417.5
18	Хяргас	68.5	324.3	39.0	35.0	466.8
19	Цагаанхайрхан	63.3	336.4		42.0	441.7
20	Улаангом		967.3	33.8	55.0	1,056.1
	Сумдын дүн	1,613.6	8,094.0	429.0	901.5	11,038.1
	Аймаг, сумдын дүн	3,243.6	13,069.1	429.0	901.5	17,643.2

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд өмнөх оны үлдэгдлээс 3,243.6 сая, Дотоод гадаадын хандив, тусламж болон бусад орлогоос 429.0 сая, Малын тоо толгойн татвараас 901.5 сая, нийт 4,574.1 сая төгрөгийг төвлөрүүлэхээр нэмж төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Сумын нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл		Дотоод гадаадын хандив, тусламж болон бусад орлого		Малын тоо толгойн татвар	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баруунтуруун	72.3	72.3		-	48.0	41.0
2	Бөхмөрөн	32.8	32.8		12.3	15.2	15.2
3	Давст	127.5	120.6		41.4	20.1	13.6
4	Завхан	88.0	88.1	85.2	41.7	43.9	30.0
5	Зүүнговь	206.8	206.9		16.0	18.5	36.7
6	Зүүнхангай	19.3	19.3	56.0	21.0	40.0	30.0
7	Малчин	25.1	25.1	77.9	68.7	74.0	60.0
8	Наранбулаг	35.0	35.0	36.0	42.9	35.0	35.0
9	Өлгий	47.1	47.1		-	14.2	11.7
10	Өмнөговь	4.2	4.2	36.4	10.8	166.3	92.5
11	Өндөрхангай	202.9	202.9	61.7	76.6	79.3	76.4
12	Сагил	102.6	102.6		61.9	60.0	41.7
13	Тариалан	174.4	174.4		3.2	-	29.7
14	Түргэн	-	-		18.5	40.0	40.0
15	Тэс	223.3	223.3		-	80.0	80.0
16	Ховд	120.5	124.5	3.0	5.6	35.0	41.1

17	Хяргас	68.5	68.5	39.0	33.2	35.0	35.0
18	Цагаанхайрхан	63.3	23.8		26.8	42.0	42.0
19	Улаангом		-	33.8	48.8	55.0	55.0
20	Увс аймаг	1,630.0	1,630.0		21.9		-
	Дүн	3,243.6	3,201.2	429.0	551.4	901.5	806.5

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд гүйцэтгэлээр урд оны үлдэгдлээс 3,201.2 сая, дотоод гадаадын хандив тусламж, бусад орлого 551.4 сая, малын тоо толгойн татвараас 806.5 сая, нийт 4,559.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 2 сум иргэдээс санал аваагүй, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй төсөл, арга хэмжээг 3 сум ИТХ-аар батлуулан зарцуулсан байна.

1.2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Малчин, Өлгий сум иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь заалтад “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.3-д “Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтална”, 6.3.5-д “Иргэдийн оролцоог хангасан байх”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн Засаг даргын харьяа хэлтэс, агентлаг, шат шатны ИТХ, төсвийн захирагчид, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн саналыг албан бичгээр авч эрэмбэлэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн нийт 42 төсөл, арга хэмжээг тайлант онд 6,605.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5 дахь заалтад “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх”, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасныг зөрчин Малчин сум 34 төсөл, арга хэмжээнээс 25 төсөл, арга хэмжээг, Өлгий сум 16 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээг тус тус иргэдээс санал авахгүйгээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.

Цаашид орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлахгүй байх албан шаардлага өгөв.

Сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2024 оны жил эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Бөхмөрөн, Наранбулаг, Өндөрхангай, Зүүнхангай сумд иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан зөрчилд албан шаардлага өгсөн байна. Үүнд:

Бөхмөрөн, Наранбулаг сум нь иргэдээс огт санал аваагүй, эрэмбэлээгүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан байна. Үүнд:

- Наранбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 1,352.8 сая төгрөгийн төсөвтэй 48 арга хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан 37 арга хэмжээнд 758.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон, мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 17/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад урд оны ажлын дутуу санхүүжилтийн арга хэмжээнд 60.0 сая төгрөг төсөвлөн 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр “Судар хүү” ХХК-д 10.0 сая төгрөг шилжүүлсэн боловч төсвийн тодотгол хийхдээ уг ажлыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 22/01 тогтоолын 2-р хавсралтаар хасаж баталсан байна.
- Бөхмөрөн сумын Орон нутгийн сангийн хөрөнгөөс 2024 онд иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 745.6 сая төгрөгийн төсөвтэй 33 арга хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан 31 арга хэмжээнд 605.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Өндөрхангай сум нь “Улаан чулуунд шинээр худаг гаргах” 30.0 төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээг, Зүүнхангай сум нь нийт 116.2 сая төгрөгийн төсөвтэй 9 төсөл, арга хэмжээг иргэдээс санал авахгүйгээр ИТХ-аар баталсан байна. Үүнд:

- Өндөрхангай сумын Орон нутгийн сангийн хөрөнгөөр тухайн жилд иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 30.0 сая төгрөгийн төсөвтэй “Улаан чулуунд шинээр худаг гаргах” ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан санхүүжүүлсэн байна.
- Зүүнхангай сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 20.0 сая төгрөгийн төсөвтэй “Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн засвар үйлчилгээ” ажил, 13.0 сая төгрөгийн төсөвтэй “Хурдан морины сэрвээ хэмжих багаж тоног төхөөрөмж худалдан авах” бараа, 15.0 сая төгрөгийн төсөвтэй “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хатуу эдлэл солих” бараа, 7.0 сая төгрөгийн төсөвтэй “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл шинэчлэх” бараа, 5.0 сая төгрөгийн төсөвтэй “Ерөнхий боловсролын сургуулийн технологийн кабинетын тоног төхөөрөмж худалдан авах” бараа, 7.2 сая төгрөгийн төсөвтэй “Хөдөөгийн 3 багийн эмчид мотоцикл худалдан авах” бараа, 8.0 сая төгрөгийн төсөвтэй “Эрүүл мэндийн төвийн модон цонхыг вакум цонхоор солих” бараа, 6.0 сая төгрөгийн төсөвтэй “4 багийн засаг даргад мотоцикл худалдан авах” бараа, 35.0 сая төгрөгийн төсөвтэй “Наадмын талбай руу цахилгааны шугам татах, холболт хийх” ажил, нийт 116.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг Зүүнхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18/1 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлуулан санхүүжүүлсэн байна.

Бусад сумдын хувьд Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдээс санал авч Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн тэмдэглэл хөтөлж, сумын ЗДТГ-т хүргүүлсэн байна. Сумдын Засаг даргын Тамгын газар тухайн төсөл, арга хэмжээнүүдийг ач холбогдол, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд уялдуулан эрэмбэлж ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй 3 сумын 31 төсөл, арга хэмжээнээс бусад нь уялдсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.1-д “Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ”, 4.1.1-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасан байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 568 төсөл, арга хэмжээг 18,779.2 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 7. Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо

(сая төгрөг)

№	Сумын нэр	Төсөл арга хэмжээний	
		тоо	мөнгөн дүн
1	Баруунтуруун	23	319.8
2	Бөхмөрөн	33	745.6
3	Давст	18	481.5
4	Завхан	23	569.6
5	Зүүнговь	21	521.3
6	Зүүнхангай	22	365.9
7	Малчин	34	480.5
8	Наранбулаг	60	1,677.8
9	Өлгий	16	255.3
10	Өмнөговь	40	577.6
11	Өндөрхангай	15	613.4
12	Сагил	22	393.0
13	Тариалан	31	758.5
14	Түргэн	18	478.3
15	Тэс	26	565.6
16	Ховд	21	417.5
17	Хяргас	25	466.8
18	Цагаанхайрхан	30	441.7
19	Улаангом	48	1,056.1
20	Аймгийн ОНХС	42	7,593.5
Нийт дүн		568	18,779.2

Эх сурвалж: Сумын ИТХ-ын тогтоолууд

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 7,593.5 сая төгрөгийн 42 төсөл, арга хэмжээг Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.

Хүснэгт 8. Аймгийн ОНХС-гийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байдал

№	Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр		ОНХС-гийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан эсэх	Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого "Алсын хараа-2050", Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцэж байна.
	Бодлого	Ерөнхий хөтөлбөрийн тоо		
1	Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	Хэрэгжиж дууссан	
2	Хүний хөгжлийн бодлого	6	15	
3	Эдийн засгийн бодлого	4	5	
4	Засаглалын бодлого	5	3	
5	Ногоон хөгжлийн бодлого	7	6	
6	Бүс, сум, орон нутгийн хөгжлийн бодлого	2	13	
Дүн		25	42	

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Хүснэгт 9. Аймгийн ОНХС-гийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдсан байдал

№	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		ОНХС-гийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан эсэх	Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 8 бүлэг болгон баталсанд нийцэж байна.
	Бодлого	Ерөнхий хөтөлбөрийн тоо		
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	5	
2	Хүний хөгжил	7	19	
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	4	
4	Эдийн засаг	6	2	
5	Засаглал	6	1	
6	Ногоон хөгжил	4	3	
7	Амар тайван, аюулгүй нийгэм	5	4	
8	Бүс, сум, орон нутгийн хөгжил	3	4	
Дүн		42	42	

Эх сурвалж: Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Харин Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.3-д “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ”, 4.3.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасныг Наранбулаг, Малчин, Бөхмөрөн сум зөрчин ОНХС-ийн эх үүсвэрээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй 31 төсөл, арга хэмжээг сумдын ИТХ-аар баталсан байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 568 арга хэмжээний 31 буюу 5.4 хувь нь Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй байна.

Хүснэгт 10. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулаагүй төсөл арга хэмжээний тоо, зөрчил гаргасан сумууд

№	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		
	Сумын нэр	Ерөнхий хөтөлбөрийн тоо	Уялдаагүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо
1	Наранбулаг	60	19
2	Малчин	34	10
3	Бөхмөрөн	33	2
Дүн		127	31

Эх сурвалж: Сумын ИТХ-ын тогтоол

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй 19 төсөл, арга хэмжээг Наранбулаг сум, 10 төсөл, арга хэмжээг Малчин сум, 2 төсөл, арга хэмжээг Бөхмөрөн сум ИТХ-аар баталсан байна.

Наранбулаг, Малчин, Бөхмөрөн сумдын Засаг дарга нарт Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.3-д “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ”, 4.3.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

1.2.3. Төсвийн тухай хуульд заасан шаардлага шалгуур хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.2.3 дахь заалтад “Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 6.2.6 дахь заалтад “Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахаар бол доор дурдсан зохицуулалт хийнэ”, 6.2.6.а-д “Тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/04 дүгээр тогтоолоор аймгийн 2024 оны төсөв батлахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7,561.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 21/01 дүгээр тогтоолоор аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийж Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7,593.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл, арга хэмжээг баталсан байна. Тодотголоор анх баталсан төсөл, арга хэмжээнээс 35.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг хасаж, 156.4 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг нэмж баталсан байна. Үүнд:

Хасагдсан төсөл, арга, хэмжээний хувьд:

1. Эко кэш хог хаягдал төлбөртэй хүлээн авах автомат машин 35.0 сая,

Нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээний хувьд:

1. Ойн зурвасын талбайд гүний худаг бүхий цахилгааны шугам татах 49.0 сая /Улаангом сум/,
2. Монгол гэр худалдан авах 10.0 сая /ШШГГ/,
3. Сийлбэртэй монгол гэр, гэрийн эд хэрэглэл худалдан авахад дэмжлэг 10.8 сая /Соёл, урлагийн газар/,
4. Уулзалт мэдүүлгийн өрөөний засвар тохижилт 13.9 сая /Цагдаагийн газар/,
5. Зуухны барилгын их засварын ажлын дутуу 9.6 сая / Улаангом сум/,
6. Аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах, үйлдвэрийн байрны засвар тохижилт 15.0 сая /ЗӨСТ/,
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ангид тоног төхөөрөмж 10.0 сая /Улаангом 5-р цэцэрлэг/,
8. Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний цахилгааны ажлын дутуу 38.1 сая /Улаангом сум/

Мөн 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 184.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотгол хийхээс өмнө тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 19 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг гэрээний дүнгээр болгон анхны төсөвт өртгийг 68.9 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.1-д “Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ”, 4.1.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх”, 4.3-д “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ”, 4.3.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэж заасан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл шаардлагатай 25 төсөл, арга хэмжээ нь зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлтэй байна. Харин аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөвт өртөг багатай төсөл, арга хэмжээнүүдийн хувьд ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод үндэслэн төлөвлөсөн байна.

1.2.4. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 75.4 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь ОНХС-ийн журам хангагдахгүй байх эрсдэл үүсэж байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-д “Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;
- Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
- Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах;
- Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
- Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах;
- Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх;
- Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;
- Ажлын байр бий болгох.

Увс аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр 18,779.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 568 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталж гүйцэтгэлээр 489 төсөл, арга хэмжээнд 13,431.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

ОНХС-аар хэрэгжүүлсэн 489 төсөл, арга хэмжээний 36 буюу 7.4 хувийг аймаг, 453 төсөл, арга хэмжээ буюу 92.6 хувийг сумдын түвшинд хэрэгжүүлсэн байна.




График 1. ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

Аймгийн ОНХС-ийн хэрэгжүүлсэн 5,192.9 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээ ОНХС-ийн журамд заасан чиг үүрэгт дараах байдлаар нийцэж байна.

Хүснэгт 11. Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ ОНХС-ийн журмыг 4.2-д заасан чиг үүрэг

(сая төгрөг)			
№	Шалгуур үзүүлэлт	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн
1	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи	16	1,035.4
2	Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	11	3,006.2
3	Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	4	404.1
4	Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах	3	437.9
5	Журам заасан чиг үүрэгт хамааралгүй	2	309.3
Нийт дүн		36	5,192.9

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн нэгтгэл судалгаа

Дээрх 36 төсөл, арга хэмжээнээс дараах 2 төсөл, арга хэмжээний хувьд хэрэгжилтийн шатанд зориулалтыг өөрчилж зарцуулсан нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцэхгүй байна. Үүнд:

- Жендер ба хөгжил /эрэгтэйчүүд/ зөвлөгөөн, статистик үзүүлэлтийн эмхэтгэл хэвлүүлэх- 10.0 сая,
- Монгол гэр худалдан авах-10.0 сая /ШШГГ/

Мөн Наадмын талбайн гүйлтийн зам 151.6 сая, Зуухны барилгын их засварын дутуу 9.6 сая, зураг төсөв, геологи судалгааны зардал 128.1 сая, нийт 289.3 сая төгрөгийг Увс аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/831 дүгээр захирамжаар барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.4-д “Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;
- Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
- Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;
- Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
- Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах;
- Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах;
- Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;
- Ажлын байр бий болгох;
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.5-д “Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

- Бэлчээрийн менежментийг сайжруулах;
- Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/
- Малын эрүүл мэндийг хамгаалах;
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- Малын чанарыг сайжруулах;
- Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;
- Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
- Малын тэжээлийн ургамал тариалах;
- Тэжээлийн нөөц бүрдүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах;
- Хортон мэрэгчидтэй тэмцэх /байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;
- Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа гэж заажээ.

Сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн 8,238.3 сая төгрөгийн 453 төсөл, арга хэмжээ ОНХС-ийн журамд заасан чиг үүрэгт дараах байдлаар нийцэж байна.

Хүснэгт 12. Сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ ОНХС-ийн журмын 4.4-д заасан чиг үүрэг

(сая төгрөг)

№	Шалгуур үзүүлэлт	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн
1	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи	105	2,096.6
2	Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	60	1,361.5
3	Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	112	1,943.7
4	Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах	22	477.4

5	Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах	16	256.4
6	Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах	6	85.7
7	Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт	2	5.3
8	Ажлын байр бий болгох	0	0
9	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа	15	220.1
10	Бэлчээрийн менежментийг сайжруулах	5	61.6
11	Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/	28	275.7
12	Малын эрүүл мэндийг хамгаалах	3	34.0
13	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	10	146.3
14	Малын чанарыг сайжруулах	4	24.5
15	Гэмт халдлага, гамшгаас хамгаалах	15	227.8
16	Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх	1	9.5
17	Малын тэжээлийн ургамал тариалах	1	20.0
18	Тэжээлийн нөөц бүрдүүлэх	34	917.7
19	Байгаль орчныг хамгаалах	1	4.0
20	Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/	3	10.1
21	Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа	1	5.0
Нийт дүн		444	8,182.9

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн нэгтгэл судалгаа

Харин дараах 9 төсөл, арга хэмжээний хувьд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцэхгүй байна.

Хүснэгт 13. Сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ ОНХС-ийн журмын 4.4-д заасан чиг үүрэгт нийцээгүй төсөл, арга хэмжээ

(сая төгрөг)

№	Сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гүйцэтгэл
1	Давст	Нохой, муур устгах	1.2	1.2
2	Наранбулаг	Цагдаагийн хэсгийн автомашины засвар	5.0	5.0
3	Наранбулаг	ЗДТГ-ын автомашины засвар үйлчилгээ	10.0	10.0
4	Өлгий	Нохой, муур хортон мэрэгч устгах зардал	2.1	2.1
5	Сагил	Машины засварт	20.0	20.0
6	Сагил	Золбин нохой, муур устгах	5.0	1.4
7	Тариалан	Ойд зориулсан бэлэг дурсгалын зүйл бэлтгэх зардал	0.7	0.7
8	Хяргас	Хангай багийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа хийх	5.0	5.0
9	Хяргас	Малчдад зориулсан сургалт хийж үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	10.0	10.0
Нийт			59.0	55.4

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн нэгтгэл судалгаа

Цаашид журамд заасан чиг үүрэгт нийцсэн төсөл, арга хэмжээг төлөвлөж байхыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

БҮЛЭГ 2

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Сагил сум 116.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, ОНХС-ийн хөрөнгийг бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан ч зориулалт бус зардал гарсан байна.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Сагил сумаас бусад нь холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Мөн Засаг даргын захирамжаар сумдад болон төсөвт байгууллагуудад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороог байгуулан ажилласан байна.

Үнэлгээний хороонд аймгийн Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, тухайн салбарын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт “Захиалагчийг төлөөлөх этгээд энэ хуулиар олгогдсон эрх, үүргийг тухайн байгууллагын холбогдох бусад этгээдэд шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Мөн Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1-д “Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх”, 4.1.1.1-д “Төсвийн тухай хуулийн 14.4-т заасныг үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг хэсэгчилж, эсхүл бүхэлд нь шилжүүлэх”, 4.1.1.2-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх” гэж заажээ.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих 42 төсөл, арга хэмжээнээс 14 төсөл, арга хэмжээний эрхийг харьяалах төсвийн захирагч нарт шилжүүлсэн байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 дүгээр захирамжаар 1 төсөл, арга хэмжээг:

1. 8-р багийн төвийн тохижилт /Улаангом сум/- 50.0 сая

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/80 дугаар захирамжаар 1 төсөл, арга хэмжээг:

1. "Шургуйн ам" газарт 20 га тариалангийн талбайн усалгааны тоног төхөөрөмж /Зүүнговь сум/-109.5 сая

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/109 дүгээр захирамжаар 1 төсөл, арга хэмжээг:

1. "Тэнгэрийн сэнтий" үндэсний бүжгэн жүжиг /Ойрад театр/ - 100.0 сая

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/122 дугаар захирамжаар 2 төсөл, арга хэмжээг:

1. Номын фонд баяжуулахад дэмжлэг үзүүлэх / 20 номын сан/ /Соёл урлагийн газар/ - 12.0 сая
2. Аялал жуулчлалын танилцуулга, ном товхимол шинээр гаргах / Байгаль орчин, аялал жуулчлалын газар/ -10 сая

Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/365 дугаар захирамжаар 1 төсөл, арга хэмжээг:

1. Терроризмтой тэмцэх зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн, холбоо харилцааны тоног төхөөрөмж /Аймгийн ЗДТГ, ТЕГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Хийлийн 0245 дугаар анги, ШШГГ/ - 39.0 сая

Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/499 дүгээр захирамжаар 1 төсөл, арга хэмжээг:

1. Аврах завины хөвөгч зогсоол худалдан авах /Онцгой байдлын газарт/ - 20.0 сая

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/559 дүгээр захирамжаар 6 төсөл, арга хэмжээг:

1. Монгол гэр худалдан авах /ШШГГ/ - 10.0 сая
2. Сийлбэртэй монгол гэр, гэрийн эд хэрэглэл худалдан авахад дэмжлэг /Соёл, урлагийн газар/ - 10.8 сая
3. Уулзалт мэдүүлгийн өрөөний засвар тохижилт /Цагдаагийн газар/ - 13.9 сая
4. Аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах, үйлдвэрийн байрны засвар тохижилт /ЗӨСТ -15.0 сая
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ангид тоног төхөөрөмж /Улаангом 5-р цэцэрлэг/ - 10.0 сая
6. Ойн зурвасын талбайд гүний худаг бүхий цахилгааны шугам татах /Улаангом сум/ - 49.0 сая

Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/612 дугаар захирамжаар 1 төсөл, арга хэмжээг:

1. Жендер ба хөгжил /эрэгтэйчүүд/ зөвлөгөөн, статистик үзүүлэлтийн эмхэтгэл хэвлүүлэх /Статистикийн хэлтэс/ - 10.0 сая

Хүснэгт 14. Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжсэн ажлын сонгон шалгаруулалт

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Тайлант жилд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан ТАХ-ний		Үүнээс									
				Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах		Олон нийтийн оролцоотой худалдан авалт		Худалдан авах ажиллагаа зарлаагүй	
		Тоо	Төсөвт өргийн дүн	Тоо	Төсөвт өргийн дүн	Тоо	Төсөвт өргийн дүн	Тоо	Төсөвт өргийн дүн	Тоо	Төсөвт өргийн дүн	Тоо	Төсөвт өргийн дүн
1	2	3=5+7+9+11+13+15	4=6+8+10+12+14+16	5	6	7	8	9	10	13	14	15	16
1	Баруунтуруун	18	303.8			3	126.8	15	177.0				
2	Бөхмөрөн	33	745.6	1	194.0	3	148.0	27	285.7			2	118.0
3	Давст	15	369.2			8	325.0	5	28.2			2	16.0
4	Завхан	23	569.6			7	283.3	13	139.9			3	146.4
5	Зүүнговь	15	395.2			6	256.0	8	124.2			1	15.0
6	Зүүнхангай	22	365.9			4	148.7	15	200.2			3	17.0
7	Малчин	31	457.5			2	97.1	20	173.4			9	187.0
8	Наранбулаг	60	1,677.8	2	352.7	6	245.0	37	439.0			15	641.1
9	Өлгий	12	174.3			1	85.0	11	89.3			0	-
10	Өмнөговь	40	577.6			4	179.3	33	332.3			3	66.0
11	Өндөрхангай	13	557.0			9	502.6		-	2	32.2	2	22.2
12	Сагил	22	393.0			2	51.0	18	313.0			2	29.0
13	Тариалан	30	712.6			10	453.1	18	244.4			2	15.0
14	Түргэн	18	478.3			4	195.5	10	129.8			4	153.0
15	Тэс	23	369.4			5	198.2	14	114.2			4	57.0
16	Ховд	21	417.5			3	200.0	18	217.5				-
17	Хяргас	25	466.8			9	342.3	14	106.0			2	18.5
18	Цагаанхайрхан	20	378.4			7	274.7	11	92.7			2	11.0
19	Улаангом	48	1,056.1	1	160.7	9	400.6	35	478.3			3	16.5
	Сумын дүн	489	10,465.5	4	707.3	102	4,512.2	322	3,685.0	2	32.2	59	1,528.8
20	Увс аймаг ОНХС	34	4,214.8	8	2,756.4	11	685.0	13	599.5			2	174.0
	Нийт дүн	523	14,680.3	12	3,463.7	113	5,197.2	335	4,284.4	2	32.2	61	1,702.8

Эх сурвалж: Аймаг, сумдын ОНХС-ийн нэгтгэл судалгаа

Увс аймгийн хэмжээнд 2024 онд шинээр 14,680.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 523 төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тендер зохион байгуулсан нийт ажлын 3,463.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт, 5,197.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 113 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 4,284.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 335 төсөл, арга хэмжээг шууд худалдан авалт, 32.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авалт хийсэн байна.

Худалдан авах ажиллагааны газар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн 18 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулжээ.

Худалдан авах ажиллагааг явуулахдаа аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 9 төсөл, арга хэмжээнд харьцуулалтын арга, 9 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргыг ашигласан байна.

Худалдан авах ажиллагааны үр дүнд 17 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулагдаж, Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан "Түрээсийн орон сууц хөтөлбөр" хэрэгжүүлэх /Увс аймаг/ төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа 3 удаа зарласан ч оролцогч ороогүй байна.

Эрх шилжүүлсэн 14 төсөл, арга хэмжээнээс “Аялал жуулчлалын танилцуулга, ном товхимол шинээр гаргах” төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, харин хэрэгжсэн 13 төсөл, арга хэмжээний хувьд дараах аргуудыг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

- Нээлттэй тендер сонгон шалгаруулалтын арга – 1
- Харьцуулалтын арга - 1
- Шууд худалдан авалтын арга - 11

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагчийн энэ хуулийн 28.1-д заасан шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг уг шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор, захиалагчид гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй тухай гомдлыг энэ хуулийн 57.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш ажлын таван өдрийн дотор тус тус хүлээн авна” гэж заасны дагуу Түргэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 38.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сургуулийн тоног төхөөрөмж” нийлүүлэх тендер сонгон шалгаруулалтад оролцогчид гомдол гаргасан байна.

Гомдлын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь заалтад “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол хянан шийдвэрлэж дуусах хүртэл хугацаанд захиалагчийг үйлдэл хийхгүй байхыг даалгах, захиалагчийн шийдвэрийг түдгэлзүүлэх шийдвэр гаргана”, 59.8 дахь заалтад “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршуулсан баримт бичиг, мэдээлэл, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт үндэслэн гомдлын үндэслэлийн хүрээнд ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянан шийдвэрлэнэ” гэж заасны дагуу “Мишээл гүн” ХХК-ийн гомдлыг Сангийн яамнаас 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 03/7055 дугаар албан бичгээр тендерийг хүчингүй болгон дахин хуульд нийцүүлэн зарлахыг мэдэгдсэн байна.

Сангийн яамнаас ирсэн чиглэлийн дагуу үнэлгээний хороо дахин хэлэлцэж “Мишээл гүн” ХХК-д гэрээ байгуулахыг сумын Засаг даргад зөвлөмж хүргүүлснийг “Ай Ти Зон” ХХК-аас эс зөвшөөрч гомдол гаргасан байна. Гомдлыг Сангийн яамнаас хянаж үзээд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 59.10.1 дэх заалтад “Тендер шалгаруулалт, эсхүл захиалагчийн шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөлт оруулах” гэж заасныг үндэслэн захиалагчийн 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 1/84 дүгээр шийдвэрийг хүчингүй болгосон байна. Захиалагч Сангийн яамны шийдвэрийг үндэслэн “Ай Ти Зон” ХХК-д гэрээ хийх эрх олгосон ч тухайн компани төсөл, арга хэмжээг нийлүүлэхээс татгалзсан тул уг төсөл арга, хэмжээ тайлант онд хэрэгжээгүй байна.

Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан 18 тендерээс 1 тендер сонгон шалгаруулалттай холбоотой Хогны авто машин /Улаангом тохижилт үйлчилгээний газар/ төсөл, арга хэмжээнд “Арби Элеваторс” ХХК гомдол гаргасныг Сангийн яамнаас хянан үзээд Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын хавсралтад заасны дагуу 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 03/1803 дугаар албан бичгээр дахин хянан үзэхийг зөвлөсөн байна. Сангийн яамны зөвлөсний дагуу үнэлгээний хороо 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу үнэлгээний хорооны гишүүдийн олонхын саналаар өмнөх шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Наранбулаг сум Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өвс тэжээлийн нөөц бэлтгэхдээ 4 хувааж тендер зарлахгүйгээр 55.5 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3 дахь хэсэгт “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн боловч 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, давтан гаргасанд албан шаардлага өгсөн байна.

Аудитаар Сагил сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 116.0 сая төгрөгийн өвс тэжээлийг худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг мөрдөхгүйгээр шууд худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага өглөө.

Худалдан авах ажиллагааны газар ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим сайтад байршуулж, тендерийн урилгыг tender.gov.mn, “Увс Худалдан авах ажиллагааны газар” facebook хаяг, UVSKHAAG@G-mail.COM цахим хаяг, МВС телевиз, Увс нам бус телевиз гэсэн орон нутгийн телевиз болон Өглөөний сониноор олон нийтэд мэдээлсэн байна. Мөн 70453262 утсаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 1.3-д “Захиалагч хууль болон бусад эрх бүхий этгээдээс баталсан төсвийн дагуу тухайн жилийн төсөвт батлагдсан бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, тайлагнах ажиллагааг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) (цаашид “цахим систем” гэх)-ээр хөтөлнө”, 1.4-д “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (цаашид “төлөвлөгөө” гэх), худалдан авах ажиллагааны тайлан (цаашид “тайлан” гэх), түүнд оруулсан аливаа өөрчлөлтийг цахим системээр хөтөлнө”, 3.1-д “Захиалагч тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд боловсруулж, журмын 2.7, 2.8-д заасан төлөвлөгөө батлуулах дарааллын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тухайн төсвийн жил дууссан даруйд цахим системээр тайлагнана”, 3.2-д “Энэ журмын 3.1-д заасан захиалагчийн тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг төсвийн ерөнхийлөн захирагч энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнана” гэж заасны дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны тайланг гаргаж www.user.tender.gov.mn системээр баталгаажуулан Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газарт цахимаар хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэгт “Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана”, 48.5 дахь заалтад “Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална” гэсэн заалтын дагуу тендерийн материалыг архивын нэгж болгосон байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан ч зориулалт бус зардал гарсан байна.

Аймаг, сумдын ИТХ-аар ОНХС-аас 2024 онд 568 төсөл, арга хэмжээг 18,779.2 сая төгрөгийн эх үүсвэрээр гүйцэтгэхээр баталсан байна. Харин 3 сум он дамжин хэрэгжсэн 4 төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулахгүйгээр үлдэгдэл санхүүжилтийг олгосон байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 15. Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний				Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний			Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний	
		Тоо	Төсөвт өртгийн дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Үүнээс дутуу		Тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Тоо	Төсөвт өртгийн дүн
								Тоо	Дүн					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Баруунтуруун	23	319,796.4	21	304,136.8	16	220,246.8		-	5	83,890.0	34,208.0	2	3,744.0
2	Бөхмөрөн	33	745,642.5	31	605,898.7	31	605,898.7			0	-	-	2	118,000.0
3	Давст	18	481,490.9	16	458,492.9	13	280,582.9		-	3	177,910.0	39,873.0	2	16,000.0
4	Завхан	23	569,618.8	20	379,209.9	19	349,709.9		-	1	29,500.0	11,800.0	3	146,408.8
5	Зүүнговь	21	521,348.4	20	504,491.7	15	319,376.7		-	5	185,115.0	38,000.0	1	15,000.0
6	Зүүнхангай	22	365,873.1	18	291,258.9	17	271,258.9			1	20,000.0	16,000.0	4	47,014.2
7	Малчин	34	480,457.5	24	283,889.1	23	238,389.1			1	45,500.0	31,850.0	10	196,064.2
8	Наранбулаг	60	1,677,826.9	45	951,645.8	42	688,089.1			3	263,556.7	165,000.0	15	641,126.9
9	Өлгий	16	255,271.9	16	251,145.0	15	231,345.0			1	19,800.0	10,000.0	0	-
10	Өмнөговь	40	577,596.9	37	504,330.8	36	478,095.8		-	1	26,235.0	-	3	66,000.0
11	Өндөрхангай	15	613,364.5	15	756,672.1	11	466,978.4	2	5,871.0	4	289,693.7	239,072.3	2	22,200.0
12	Сагил	22	392,978.4	20	360,818.8	20	360,818.8						2	29,000.0
13	Тариалан	31	758,493.2	29	713,380.4	24	585,270.9		-	5	128,109.5	78,924.9	2	15,029.1
14	Түргэн	18	478,286.0	12	178,730.2	12	178,730.2	1	13,500.0	0	-	-	6	291,000.0
15	Тэс	26	565,581.7	23	785,201.4	22	775,201.4	3	47,090.0	1	10,000.0	8,000.0	4	57,000.0
16	Ховд	21	417,500.0	21	406,550.3	19	326,560.3	1	160.5	2	79,990.0	69,910.0		
17	Хяргас	25	466,811.0	25	447,830.3	22	372,820.4		-	3	75,009.9	55,406.9	-	-
18	Цагаанхайрхан	30	441,718.5	26	370,999.7	26	370,999.7	1	2,987.1	-	-	-	5	85,189.5
19	Улаангом	48	1,056,101.3	44	1,000,623.9	42	834,180.3	18	8,166.1	2	166,443.6	119,112.4	4	46,500.0
Сумын дүн		526	11,185,757.9	463	9,555,306.7	425	7,954,553.4	26	77,774.7	38	1,600,753.4	917,157.5	67	1,795,276.7
20	Увс аймаг ОНХС	42	7,593,472.9	38	5,691,026.2	35	4,781,770.3	1	9,600.0	3	909,255.9	501,574.3	4	1,212,100.0
Нийт дүн		568	18,779,230.8	501	15,246,333.0	460	12,736,323.7	27	87,374.673	41	2,510,009.3	1,418,731.8	71	3,007,376.7

Эх сурвалж: Аймаг, сумдын ОНХС-ийн нэгтгэл судалгаа

Тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн 15,246.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 501 төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 12,736.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Харин бүрэн хэрэгжүүлсэн 27 төсөл, арга хэмжээний 87.4 сая төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгоогүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хэрэгжилт дутуу байгаа 2,510.0 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 41 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд нь үндэслэн тайлант онд 1,417.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй, гэрээ сунгасан дээрх төсөл, арга хэмжээнүүдийг гүйцэтгэгч компаниар хийж гүйцэтгүүлэхийг зөвлөмж болголоо.

ОНХС-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 32.5 сая

төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 1 зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүлсэн байна. Үүнд:

1. Давст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 15/01 дүгээр тогтоолоор Хандгайт багийн бог малын тарилгын хашаа авах төсөл, арга хэмжээг баталж, 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр 2.2 сая төгрөг, 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 5.2 сая төгрөг, нийт 7.5 сая төгрөгийг “Хүдэнгийн сүрэг” ХХК-д шилжүүлсэн боловч Давст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 18/01 тогтоолоор тодотгол хийхдээ уг ажлыг хасч баталсанд албан шаардлага,
2. Малчин сумын Орон нутгийн хөгжлийн санд Тогтвортой амьжиргаа-3 төслөөс урамшуулал гэж 50.0 сая төгрөг орж ирснээс 5.0 сая төгрөгийг иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт сурталчилгаанд зарцуулахдаа 4 багийн дарга, Санхүү албаны дарга, Төсөв, төрийн сангийн мэргэжилтний данс руу гүйлгээ хийсэн зөрчилд албан шаардлага,
3. Наранбулаг сумын Засаг дарга нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс сумын иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолоор баталсан Дэчинчойбол хийдийг хашаажуулах арга хэмжээнд Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/189 дүгээр захирамжаар 20.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага,
4. Ховд сум 2023 онд хийж дуусгахаар гэрээ байгуулсан “Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн дотно тохижилт”-ын 70.0 сая төгрөгийн арга хэмжээ, “Дунд хэвийн худаг сэргээн засварлах” 10.0 сая төгрөгийн арга хэмжээ, нийт 80.0 сая төгрөгийн 2 ажлыг гэрээний хугацаандаа хийж дуусгаагүй зөрчилд зөрчлийг арилгах зөвлөмжийг тус тус өгсөн байна.

Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална”, 33.2.10 дахь заалтад “Хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/”, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 3.2.1-д “Ажлын хэсгийн боловсруулсан тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг санал тус бүрээр хэлэлцэн батлах, нийтэд мэдээлэх”, 4.3.6-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдан ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч тухайн онд санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрийг нэгдсэн жагсаалтад оруулах” гэж заасныг зөрчин сумын ИТХ-аар батлуулаагүй он дамжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчилд албан шаардлага өглөө. Үүнд:

- Өндөрхангай сум- Шүдний тоног төхөөрөмж худалдан авахад 0.8 сая, өвсний үнэд 13.2 сая,
- Цагаанхайрхан сум- Сумын өвсний нөөц бүрдүүлэх төсөл, арга хэмжээний үлдэгдэлд 5.9 сая,
- Тэс сум- Орон нутаг судлах музейн танхим тохижуулах төсөл арга хэмжээний үлдэгдэлд 4.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчин Түргэн сум Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, гамшгийн бэлэн байдлын зэрэгт шилжээгүй байхад сумын ИТХ-аар батлуулсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах” төсөл арга хэмжээний хүрээнд гамшигт ажилласан тайлан, нотлох баримтгүйгээр тээвэр шатахууны зардалд 9.8 сая зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.3 дахь заалтад “Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.7-д Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй, 4.7.2-д “Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал” гэж заасныг зөрчин Хяргас сум “Малчдад зориулсан сургалт хийх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах” -д 10.0 сая, “Хангай багийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа хийх”-д 5.0 сая, нийт 15.0 сая төгрөгийг спортын тэмцээний шагнал, хүлээн авалт, бэлэг дурсгал, цай хоолны зардалд зарцуулсанд албан шаардлага өглөө.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг 5.0 сая төгрөг байна гэж заасныг зөрчин Наранбулаг сум Үндэсний баяр наадмын зардалд 10.0 сая төгрөгийг сумын ИТХ-ын тогтоолоор батлан зарцуулсанд албан шаардлага өглөө.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1 дэх заалтад “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.3.4 дэх заалтад “Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.7-д Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй”, 4.7.3-т “Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа” гэж заасныг зөрчин аймгийн ОНХС-аас “Жендер ба хөгжил /эрэгтэйчүүд/ зөвлөгөөн, статистик үзүүлэлтийн эмхэтгэл хэвлүүлэх” төсөл, арга хэмжээний хүрээнд 10.0 сая төгрөгийг Статистикийн хэлтэст эрх шилжүүлж зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өглөө.

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчсөн доорх зөрчлүүдэд зөвлөмж өглөө. Үүнд:

- ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 8.1-д "ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ" гэж заасныг зөрчиж аймгийн Засаг даргын 2024 оны А/831 дүгээр захирамжаар аймгийн ОНХС-аас 289.3 сая төгрөгийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн,
- Аймгийн ИТХ-ын 2024 оны 21/01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтын 1.14-д Зураг төсөв, геологи судалгааны зардалд 334.1 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 139.9 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд: Зургийн үнийн орлогоос 11.8 сая төгрөгийг зарцуулж, 128.1 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн,
- Наранбулаг сум Сумын ИТХ-аар батлуулсан "Малын ангилан ялгалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал" төсөл, арга хэмжээний хүрээнд 8.6 сая төгрөгийг зарцуулснаас 7.6 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан,
- Малчин сум Сумын ИТХ-аар батлуулсан "Ногоон байгууламжийн арчилгааны зардал" төсөл, арга хэмжээний хүрээнд 6.6 сая төгрөгийг зарцуулснаас 3.1 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, "Сургалт сурталчилгааны зардал" төсөл, арга хэмжээний хүрээнд 5.0 сая төгрөгийг зарцуулснаас 2.0 сая

төгрөгийн тээвэр шатахууны зардалд, 3.0 сая төгрөгийн бичиг хэрэг, бараа материалын зардлыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.

Соёлын сайдын 2024 оны А/128 дугаар тушаалаар “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээний хүрээнд Увс аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт 30.0 сая төгрөгийн эрх шилжүүлсэн байна.

Увс аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 19.8 сая төгрөгөөр сийлбэртэй гэр, 8.7 сая төгрөгөөр ширээ, сандал, 1.5 сая төгрөгөөр авдар худалдан авсан байна.

Аймгийн ОНХС-аас аймгийн Засаг даргын А/559 дүгээр захирамжаар “Сийлбэртэй монгол гэр, гэрийн эд хэрэглэл худалдан авахад дэмжлэг /Соёл, урлагийн газар/” төсөл, арга хэмжээний хүрээнд 10.8 сая төгрөгийг Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт эрх шилжүүлсэн байна.

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь тус бүр нь 5.4 сая төгрөгийн үнэ бүхий “Хаан, хатан сэнтий сандал” 2 ширхэг сандал худалдан авсан байна. Тус сандал нь зах зээлийн ханшаас хэт өндөр үнэтэй, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байх тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар Монгол Улсын Ерөнхий аудитор уламжлав.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх боломж байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүн 81.3 хувьтай байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3 дахь заалтад “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” 14.3 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэж заасан байна.

Аймгийн ОНХС-аас хийгдсэн хэрэгжилт дутуу 3 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

Хүснэгт 16. Аймгийн ОНХС-аас хийгдсэн хэрэгжилт дутуу 3 төсөл, арга хэмжээ

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Тайлбар
1	Нийтийн халуун усны барилга, тоног төхөөрөмж /Малчин сум/	256.0	128.0	Өмнөх онд 128.0 сая төгрөг олгосон. Тайлант онд санхүүжилт олгоогүй. Өмнөх онд хийсэн уг асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр Төрийн аудитын газрын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 264 дүгээр албан бичгийг МУЕА-т хүргүүлсэн.
2	Наадмын талбайн гүйлтийн зам /Улаангом сум/	319.1	167.6	Гэрээний хугацааг сунгасан.
3	Зураг төсөв	102.3	30.7	Нийт 19 зураг төсөв, инженер геологийн судалгаа хийлгэхээр гэрээ байгуулснаас 17 нь бүрэн хийгдэж 2 нь зураг, төсөв дутуу хийгдсэн байна.

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн гүйцэтгэлийн нэгтгэсэн судалгаа

Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/-ын зураг төсөв 55.8 сая төгрөгөөр хийгдэхээр гэрээ байгуулж 16.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/-ын зураг төсөв 46.5 сая төгрөгөөр хийгдэхээр гэрээ байгуулж 14.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дээрх 2 зураг, төслийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр "Пауэрхаус девелопмент" ХХК боловсруулахаар гэрээ байгуулсан бөгөөд зураг, төсвийн ажлыг гүйцэтгэж Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахаар хүргүүлсэн байна.

Сумдын ОНХС-аас хийгдсэн хэрэгжилт дутуу 38 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнд хүрээгүй байна.

Хүснэгт 17. Сумдын ОНХС-аас хийгдсэн хэрэгжилт дутуу 38 төсөл, арга хэмжээ

(сая төгрөг)

Д/д	Сумдын нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт
1	Баруунтуруун	5	83.9	34.2
2	Давст	3	177.9	39.9
3	Завхан	1	29.5	11.8
4	Зүүнговь	5	185.1	38.0
5	Малчин	1	45.5	31.9
6	Наранбулаг	3	263.6	165.0
7	Өлгийн	1	19.8	10.0
8	Өмнөговь	1	26.2	-
9	Өндөрхангай	4	289.7	239.1
10	Сагил		-	-
11	Тариалан	5	128.1	78.9
12	Түргэн	0	-	-
13	Тэс	1	10.0	8.0
14	Хяргас	3	75.0	55.4
15	Улаангом	2	166.4	119.1
	Нийт	38	1,600.7	917.2

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн гүйцэтгэлийн нэгтгэсэн судалгаа

Харин бүрэн хэрэгжсэн 460 төсөл, арга хэмжээ буюу 81.3 хувь нь зорилтод түвшний үр дүнд хүрсэн байна.

Хүснэгт 18. Бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээ, зорилтод түвшин

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүнд	
		тоо	гэрээний дүн	хүрсэн ТАХ	
				тоо	Гэрээний дүн
1	2	3	4	5	6
1	Баруунтуруун	16	220.2	16	220.2
2	Бөхмөрөн	31	605.9	31	605.9
3	Давст	13	280.6	13	280.6
4	Завхан	19	349.7	19	349.7
5	Зүүнговь	15	319.4	15	319.4
6	Зүүнхангай	17	271.3	17	271.3
7	Малчин	23	238.4	23	238.4
8	Наранбулаг	42	688.1	42	688.1
9	Өлгий	15	231.3	15	231.3
10	Өмнөговь	36	478.1	36	478.1
11	Өндөрхангай	11	467.0	11	467.0
12	Сагил	20	360.8	20	360.8
13	Тариалан	24	585.3	24	585.3
14	Түргэн	12	178.7	12	178.7
15	Тэс	22	775.2	22	775.2
16	Ховд	19	326.6	19	326.6
17	Хяргас	22	372.8	22	372.8
18	Цагаанхайрхан	26	371.0	26	371.0
19	Улаангом	42	834.2	42	834.2
	сумын дүн	425	7,954.6	425	7,954.6
20	Увс аймаг ОНХС	35	4781.8	35	4781.8
	НИЙТ ДҮН	460	12,736.3	460	12,736.3

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн гүйцэтгэлийн нэгтгэсэн судалгаа

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц, зохих үр нөлөөтэй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 1.4-д “ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” гэж заасан байна.

Аймаг, суманд ОНХС-ийн эх үүсвэр бий болсноор орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн тулгамдсан асуудлаа зохих хэмжээнд бие даан шийдвэрлэх боломжтой болсон байна.

Сум өөрийн төсвөөр шийдвэрлэх боломжгүй ажлуудаа Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.1.2-т заасны дагуу аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлж, өндөр төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт “Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт,

хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна” гэж заасны дагуу ихэнх сумд иргэдийн саналд үндэслэн шаардлага, шалгуурыг хангасан төсөл, арга хэмжээг тухайн шатны ИТХ-аар баталж хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 19. Аймаг, сумдын ОНХС-ын иргэдийн санал авсан төсөл, арга хэмжээ, төсөвт өртөг

№	Сум, дүүргийн нэр	Нийт санал өгсөн иргэдийн тоо	Нийт санал /ажлаар/		Батлагдсан санал		Цуцлагдсан санал	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Баруунтуруун	1,093	34	430.2	23	319.8	11	0.1
2	Бөхмөрөн				33	745.6		-
3	Давст	186	37	631.5	18	481.5	19	150.0
4	Завхан	968	28	581.2	23	569.6	5	11.6
5	Зүүнговь	1,080	23	570.3	21	521.3	2	49.0
6	Зүүнхангай	212	66	7,457.5	22	365.9	44	7,091.6
7	Малчин	243	51	752.3	34	480.5	17	271.8
8	Наранбулаг				60	1,677.8		-
9	Өлгий	409	19	362.2	16	255.3	3	106.9
10	Өмнөговь	1,941	65	879.4	40	577.6	25	0.3
11	Өндөрхангай	399	399	4,406.6	15	613.4	384	3,793.2
12	Сагил	406	120	963.0	22	393.0	98	570.0
13	Тариалан	473	473	1,313.7	31	758.5	444	0.6
14	Түргэн	277	26	1,512.6	18	478.3	8	1,034.3
15	Тэс	810	36	819.0	26	565.6	10	0.3
16	Ховд	335	23	501.5	21	417.5	2	84.0
17	Хяргас	118	66	1,095.0	25	466.8	41	0.6
18	Цагаанхайрхан	442	41	520.7	30	441.7	11	0.1
19	Улаангом	876	105	1,815.9	48	1,056.1	57	0.8
20	Аймгийн ОНХС	2,723	313	73,733.5	42	7,593.5	271	66,140.1
Дүн		12,991	1,925	98,346.3	568	18,779.2	1452	79,305.3

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн гүйцэтгэлийн нэгтгэсэн судалгаа

Аймгийн хэмжээнд 12991 иргэнээс давхардсан тоогоор нийт 1925 санал ирснээс 568 санал нь тухайн шатны ИТХ-аар батлагдсан байна.

Эндээс харахад иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг ОНХС-ийн хөрөнгөөр зохих хэмжээнд шийдвэрлэсэн байх тул орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц, зохих үр нөлөөтэй байна гэж үзэхээр байна.

Харин 2 сум иргэдээс огт санал аваагүй, 4 сум иргэдийн саналаар дэмжигдээгүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчлийг тайлангийн 1.2.1 дэх хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээнүүд иргэдийн амьдрах таатай орчин бүрдэх, орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлэхээр байна. Үүнд:

- Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил /Улаангом сум/ - 789.7 сая,
- Нийтийн эзэмшлийн теле хяналтын цэгүүдийн тоног төхөөрөмжийн засвар, шинэчлэл /Увс аймаг дахь Цагдаагийн газар/ - 74.0 сая,
- ДДТ2-оос Саруул өргөө, 48 айлын байр хүртэлх дулааны шугамын өргөтгөл шинэчлэл /Улаангом сум 3-р баг/ - 415.1 сая,

- Хогны авто машин /Улаангом тохижилт үйлчилгээний газар/ - 129.6 сая,
- 12-р багийн гэрэлтүүлэг /Улаангом сум/ - 142.3 сая,
- Бор толгойн гэрэлтүүлэг /Улаангом сум, 2-р баг/ - 49.7 сая,
- Улаангом сумын 10-р багийн Дунд хорооллын гудамжны гэрэлтүүлгийн ажлын үргэлжлэл – 77.4 сая

Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээнүүд ашиглагч байгууллагын саналаар иргэдийн амьдрах таатай орчин бүрдэх, орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлэхээр байна.

Хүснэгт 20. Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний сайн жишээ

1	Баруунтуруун	Сумын төвийн "Туруун багийн худаг засварлах" ажил нь бага төсөвт өртгөөр хуучин худгийн барилгыг засварлаж халаалттай болгосноор иргэдийн ундны усан хангамж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн худагтай болсон.
2	Бөхмөрөн	Ногоон бүсийн камержуулалтын ажил нь сумын төвийг бүхэлд камержуулснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг тухай бүрд нь илрүүлэх, гэмт хэргийг таслах зогсоход чухал ач холбогдолтой төсөл, арга хэмжээ болсон.
3	Давст	Эрүүл мэндийн төв рентген аппараттай болсноор 80 гаруй иргэнд цээжний хөндийн зураг ясны гэмтлийн зураг авч бэртэл гэмтлийг тодорхойлох мөн аймгийн төв явж үзүүлдэг байсан бол сумандаа үздэг болсонд ард иргэд сэтгэл ханамжтай байна.
4	Завхан	Хөх нурууны багийн төвийн худаг засварлах ухаалаг төхөөрөмж тавих ажил нь хөдөөгийн багийн иргэдэд ундны цэвэр усны худагт нарны эрчим хүч ашигласан нь иргэдийн эдийн засаг, санхүүг хэмнэхэд нөлөөтэй ажил болсон.
5	Зүүнговь	Тохой, цагаан голд хийгдсэн мал угаалгын ванн нь мал орж гарах, ус шүүх талбай зэрэг нь сайн жишээнд тооцогдохуйц болсон.
6	Зүүнхангай	Хөдөөгийн 3 багийн эмчийг мотоциклтой болгосон.
7	Малчин	Сумын төвийн камержуулалтын ажил нь сумын төвийн тодорхой хэсгийг камержуулснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг тухай бүрд нь илрүүлэх, гэмт хэргийг таслах зогсоход чухал ач холбогдолтой төсөл, арга хэмжээ болсон.
8	Наранбулаг	Хойлдоон хөх үзүүрийн худаг засварлах ажил нь хөдөөгийн багийн иргэн малчид усан хангамжаар хангагдаж, ашиглагдахгүй байсан бэлчээр усаар хангагдсан.
9	Өлгий	Хогийн цэгийг хумих, тор татах ажил нь олон нийтийн эрх ашигт нийцсэн, хоггүй орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн ажил хийгдсэн.
10	Өмнөговь	Нийт 5 ширхэг худгийн засвар хийгдсэнээр бэлчээрийн усан хангамж сайжирсан.
11	Өндөрхангай	Хог хаягдлын 80 га талбайг бүрэн цэвэрлэж устгаж шинээр хог хаях ухвар байгуулж эмнэлгийн хог шатаах зуух худалдан авч хогийн цэг дээр байршуулсан
12	Сагил	Сумын төвийн камержуулалт үр дүнтэй ногоон бүс болоход 1 алхам дөхсөн. Гэмт хэрэг, зөрчил багассан.
13	Тариалан	Сумын төвийн тохижилт, гэр хорооллын гудамж, багийн төвүүдэд нарны эх үүсвэртэй гэрэлтүүлэг хийсэн /300 ш/
14	Түргэн	Камержуулалт хийснээр "Ногоон сум" болсон
15	Тэс	Олон нийтийн газар 00 нэмэгдүүлэх
16	Ховд	Сум өөрийн төсвөөрөө засмал замаа нэмэгдүүлсэн.
17	Хяргас	Хөдөөгийн баг Хайрхан багийн төвийг 29790.0 сая төгрөгөөр тохижуулж багийн иргэдийн багийн төвөөс авах үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлсэн.
18	Цагаанхайрхан	2024 онд хэрэгжүүлсэн сумын төв, сургууль, цэцэрлэгийг бүрэн камержуулснаар хэрэг зөрчил гарах, малын хулгай болон орон байр, эд хөрөнгийн хулгай, бусад хэрэг зөрчил гарахаас бүрэн сэргийлж чадсан.
19	Улаангом	1. 6-р багт байрлах худагт 1 цагт 2-3 тн ус цэвэршүүлэх хүчин чадалтай усан дахь элс шавар, зэв, хөгц, эрдэс, хатуулаг давс хужир, төмөр хар тугалга, хүнд мятал, шохой хлорид үлдэгдэл, нян бактери зэргийг шүүх 3 давхар шүүлтүүртэй цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан нь иргэдийн эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлсэн. 2. Хуучин гражийн газрыг чөлөөлж иргэдийн ая тухтай орчин бүрдүүлэхээр орон сууцуудын гадна 55 авто машины зогсоол хийгдсэн. 3. Улаангом сумын орох, гарах хэсгийн буюу Гашууны голын гүүрэн дээр 5*9 харьцаатай авто замаас дээш 5 метрийн өндөртэй аркийг босгож автомашины дугаар илрүүлдэг хяналтын камер 2 ширхэг, чиглэлийн хяналтын камер 2ш камерыг суурилуулж аймгийн камерын нэгдсэн төвд холболт хийлээ. Энэ нь аймгийн төв руу орж, гарсан авто машинуудыг нэгдсэн системд бүртгэдэг болсон нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн.

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн гүйцэтгэлийн нэгтгэсэн судалгаа

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.**2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.**

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.12-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн ашиглалт хэвийн байна.

Тайлант онд бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн ашиглалтын байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 21. Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн ашиглалт

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт					
		тоо	гэрээний дүн	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй ТАХ		Зориулалтын бус ашиглаж буй ТАХ		Огт ашиглаагүй ТАХ	
				тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн
1	2	3	4	9	10	11	12	13	14
1	Баруунтуруун	16	220.2	16	220.2				
2	Бөхмөрөн	31	605.9	31	605.9				
3	Давст	13	280.6	13	280.6				
4	Завхан	19	349.7	19	349.7				
5	Зүүнговь	15	319.4	15	319.4				
6	Зүүнхангай	17	271.3	17	271.3				
7	Малчин	23	238.4	23	238.4				
8	Наранбулаг	42	688.1	42	688.1				
9	Өлгий	15	231.3	15	231.3				
10	Өмнөговь	36	478.1	36	478.1				
11	Өндөрхангай	11	467.0	11	467.0				
12	Сагил	20	360.8	20	360.8				
13	Тариалан	24	585.3	24	585.3				
14	Түргэн	12	178.7	8	137.7			4	41.0
15	Тэс	22	775.2	22	775.2				
16	Ховд	19	326.6	19	326.6				
17	Хяргас	22	372.8	22	372.8				
18	Цагаанхайрхан	26	371.0	26	371.0				
19	Улаангом	42	834.2	42	834.2				
	Сумын дүн	425	7,954.6	421	7,913.6	-	-	4	41.0
20	Увс аймаг ОНХС	35	4,781.8	35	4,781.8				
	Нийт дүн	460	12,736.3	456	12,695.3	-	-	4	41.0

Эх сурвалж: Аймаг сумдын ОНХС-ийн нэгтгэсэн судалгаа

ОНХС-ийн санхүүжилтээр тайлант онд 460 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 12,736.3 сая төгрөгийн хөрөнгөөс 456 төсөл, арга хэмжээний 12,695.3 сая

төгрөгийн хөрөнгө зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглагдаж байна.

Харин Түргэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр 41.0 сая төгрөгийн 4 зураг, төсөв хийлгэсэн ч ашиглаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан байхад сумын газрын төлөвлөлтөд тусгагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй 10.0 сая төгрөгийн баяр наадмын талбайн зураг төсөв, 7.0 сая төгрөгийн хүүхэд, залуучуудын чөлөөт амралтын бүсийн зураг төсөв, 5.0 сая төгрөгийн мал угаалгын ванны зураг төсөв, 19.0 сая төгрөгийн 3 км замын далангийн зураг төсвийн ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.

Дээрх зураг төсвийн дагуу хийгдэх барилга, байгууламж, замын ажлыг хэрэгжүүлэх газрын байршил өөрчлөгдөх, хугацаа алдсанаас өртөг нэмэгдэх зэрэг тохиолдолд тухайн зураг төсвүүд ашиглах боломжгүй болох эрсдэл үүсэж болзошгүй байна.

2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Хүснэгт 22. Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд ашиглагч байгууллагын зүгээс өгсөн чанарын үнэлгээ

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ		
		тоо	гэрээний дүн	ТАХ-ний тоо /Сайн/	ТАХ-ний тоо /Дунд/	ТАХ-ний тоо /Хангалтгүй/
1	2	3	4	15	16	17
1	Баруунтуруун	16	220.2	12	4	
2	Бөхмөрөн	31	605.9	31	-	
3	Давст	13	280.6	10	3	
4	Завхан	19	349.7	18	1	
5	Зүүнговь	15	319.4	12	3	
6	Зүүнхангай	17	271.3	17	-	
7	Малчин	23	238.4	22	1	
8	Наранбулаг	42	688.1	42	-	
9	Өлгий	15	231.3	15	-	
10	Өмнөговь	36	478.1	35	1	
11	Өндөрхангай	11	467.0	11	-	
12	Сагил	20	360.8	10	10	
13	Тариалан	24	585.3	24	-	
14	Түргэн	12	178.7	12	-	
15	Тэс	22	775.2	21	1	
16	Ховд	19	326.6	19	-	
17	Хяргас	22	372.8	22	-	
18	Цагаанхайрхан	26	371.0	23	3	

19	Улаангом	42	834.2	42	-	
	Сумын дүн	425	7,954.6	398	27	-
20	Увс аймаг ОНХС	35	4,781.8	34	1	
	Нийт дүн	460	12,736.3	432	28	-

Эх сурвалж: Аймаг сумдын ОНХС-ийн нэгтгэсэн судалгаа

Тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн 460 төсөл, арга хэмжээнээс ашиглагч байгууллагын чанарын үнэлгээгээр 432 төсөл, арга хэмжээг сайн, 28 төсөл, арга хэмжээг дунд гэж үнэлсэн ба хангалтгүй хэрэгжсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Цаашид ОНХС-ын хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн чанарт анхаарч явцын хяналтын үр нөлөөг дээшлүүлэхийг зөвлөлөө.

БҮЛЭГ 3

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН,
ХЯНАЛТЫГ ЗОХИХ ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.**

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт зохих түвшинд хэрэгжсэн байна.

3.1.1 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналтыг хэрэгжүүлсэн, харин Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 64.1.1 дэх заалтад “Засаг даргын болон Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих”, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын чиг үүрэг”, 3.2.2 дэх заалтад “Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/19 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Улаангом суманд хийгдэж байгаа дараах төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажлын явц байдалтай газар дээр нь танилцах, ажлын гүйцэтгэлд хяналт хийх, үйл ажиллагааг нь эрчимжүүлэн ажиллах болон орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, гүйцэтгэлд хяналт хийсэн байна. Үүнд:

- Наадмын талбайн гүйлтийн зам /320.0 сая төгрөг/,
- Нийтийн эзэмшлийн теле хяналтын цэгүүдийн тоног төхөөрөмжийн засвар, шинэчлэл /78.3 сая төгрөг/,
- ДДТ2-оос Саруул өргөө, 48 айлын байр хүртэлх дулааны шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил /899.9 сая төгрөг/
- Улаангом сумын 3-р 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар-ТНХ ХХК-ний уулзвар-Цастогтох дэлгүүрийн уулзвар-Галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэлийн ажил /2,000.0 сая төгрөг/

Тайлант онд Зүүнговь, Зүүнхангай, Өндөрхангай, Сагил, Тариалан, Ховд, Хяргас, Улаангом сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт шалгалт хийсэн байна.

Бусад сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд хяналт хийгээгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Засгийн газрын 2020 оны 206 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар хяналт-шинжилгээ, үнэлгээг аймаг, нийслэл, сум,

дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ гэж заасан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна. Харин сумдын 2024 оны ажлыг дүгнэхдээ ОНХС-ийн хэрэгжилтийг нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

Хүснэгт 23. Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд хийсэн хяналтын дүн

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг хэрэгжүүлсэн эсэх			
		тоо	2024 олгосон санхүүжилтийн дүн	ИТХ		Дотоод аудит	
				тийм	үгүй	тийм	үгүй
1	2	3	4	9	10	11	12
1	Баруунтуруун	21	254.5		1		1
2	Бөхмөрөн	31	605.9		1		1
3	Давст	15	320.5		1		1
4	Завхан	20	360.5		1		1
5	Зүүнговь	15	290.4	1			1
6	Зүүнхангай	18	287.3	1			1
7	Малчин	24	260.2		1		1
8	Наранбулаг	45	863.1		1		1
9	Өлгий	15	206.8		1		1
10	Өмнөговь	36	478.1		1		1
11	Өндөрхангай	13	527.9	1			1
12	Сагил	20	360.8	1			1
13	Тариалан	29	664.2	1			1
14	Түргэн	12	165.2		1		1
15	Тэс	23	461.8		1	1	
16	Ховд	21	396.3	1			1
17	Хяргас	25	428.3	1			1
18	Цагаанхайрхан	26	354.3		1		1
19	Улаангом	44	952.3	1			1
	сумын дүн	453	8,238.3	8	11	1	18
20	Увс аймаг ОНХС	36	5,192.9	1			1
	нийт дүн	489	13,431.2	9	11	1	19

Эх сурвалж: Аймаг сумдын ОНХС-ийн нэгтгэсэн судалгаа

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10 дахь заалтад “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч дотоод аудиттай байх талаар болон дотоод аудитын чиг үүргийг тусгажээ.

Мөн “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль,

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина" гэж заасан байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр 2024 онд Тэс сумаас бусад сумын ОНХС-ийн зарцуулалтад хяналт хийгээгүй гэж ирүүлсэн байна.

Иймд Төсвийн тухай хууль болон Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хяналтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж болголоо.

3.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар гэрээний дагуу хэрэгжүүлж байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт "Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 35.1.1 дэх заалтад "Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих", 35.1.4 дэх заалтад "Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах", 35.1.6 дахь заалтад "Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах", 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт "Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 37.1.4 дэх заалтад "Барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах", 37.1.9 дэх заалтад "Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах" гэж заажээ.

Мөн Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.4-д "Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг", 4.4.1.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах", 5.3.1-д "Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ", 5.3.2-д "Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-т заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана" гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 01/2024 дугаар "Аймагт

хэрэгжүүлэх барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулан ажилласан байна.

Уг гэрээнд заасны дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн томоохон төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үе шатны ажил болгон дээр хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж, чиглэл өгч ажиллажээ. Мөн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнүүдэд аймгийн Засаг даргын улсын комисс ажиллуулах захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд сумын Засаг даргын захирамж болон ашиглагч байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг захиалагчийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ирсэн байна.

Цаашид сумдад хэрэгжиж байгаа барилга байгууламж, их засварын ажлуудад Барилгын тухай хуульд заасны дагуу захиалагчийн болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай байна. Тухайлбал: Наранбулаг суманд хэрэгжсэн 232.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Соёлын төвийн их засвар" төсөл, арга хэмжээнд захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Иймд барилга байгууламж, их засварын ажилд тавих хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх асуудлаар харьяа Төсвийн захирагч нарт чиглэл хүргүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагчид зөвлөлөө.

3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 24. Аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

№	Зөвлөмжийн утга	Биелэлтийн Хувь
1	Орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлахгүй байх /Наранбулаг, Бөхмөрөн сумын ИТХ-д /	100%
2	Хүүхдийн цэцэрлэгийн засварын ажлыг бодит өртгөөр нь данс бүртгэлд тусгах. /Наранбулаг сумын Засаг даргад/	100%
3	ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэн Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлж ажиллах. /Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргад/	100%
4	Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй 41 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэх. /Аймгийн Засаг даргад/	100%
Биелэлтийн дундаж хувь		100%

Эх сурвалж: ТАГ-ын Бүртгэл мэдээний маягт, аймаг сумдын ОНХС-ийн нэгтгэсэн судалгаа

Аймаг, сумдын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 25. Аймаг, сумдын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчил, хэрэгжилт

№	Зөрчил шийдвэрлэлтийн утга	Биелэлтийн Хувь
Албан шаардлага		
1	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулсан төсөв, хөрөнгө зарцуулах 6,253.1 сая төгрөгийн 52 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн 8 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байсан.	100%
2	Өндөрхангай сумын Орон нутгийн сангийн хөрөнгөөр тухайн жилд иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 30.0 сая төгрөгийн төсөвтэй “Улаан чулуунд шинээр худаг гаргах” ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан санхүүжүүлсэн байсан.	100%
3	Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудаст Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17.5 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 102.0 сая төгрөгийн 7 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 173.5 сая төгрөгийн 13 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус байршуулаагүй байна. Мөн 25 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байсан.	100%
4	Малчин сумын Орон нутгийн хөгжлийн санд Тогтвортой амьжиргаа-3 төслөөс орж ирсэн урамшууллын 50.0 сая төгрөгөөс 5.0 сая төгрөгийг иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт сурталчилгаанд зарцуулахдаа 4 багийн дарга, Санхүү албаны дарга, Төсөв, төрийн сангийн мэргэжилтний данс руу гүйлгээ хийсэн байсан.	100%
5	Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 22.0 сая төгрөгийн 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 19.2 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 7.7 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус байршуулаагүй байсан.	100%
6	Наранбулаг сумын Засаг дарга нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 55.5 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бэлтгэхдээ 4 хувааж тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байсан.	Хугацаа болоогүй
7	Наранбулаг сумын Засаг дарга нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс сумын иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 22/01 дугаар тогтоолоор баталсан Дэчинчойбол хийдийг хашаажуулах арга хэмжээнд Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/189 дүгээр захирамжаар 20.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байсан.	Хугацаа болоогүй
8	Наранбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 1,352.8 сая төгрөгийн төсөвтэй 48 арга хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан 37 арга хэмжээнд 758.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон, мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 17/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад урд оны ажлын дутуу санхүүжилтийн арга хэмжээнд 60.0 сая төгрөг төсөвлөн 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр “Судар хүү” ХХК-д 10.0 сая төгрөг шилжүүлсэн боловч төсвийн тодотгол хийхдээ уг ажлыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 22/01 тогтоолын 2-р хавсралтаар хасаж баталсан байсан.	Хугацаа болоогүй
9	Бөхмөрөн сумын Орон нутгийн сангийн хөрөнгөөс 2024 онд иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 745.6 сая төгрөгийн төсөвтэй 33 арга хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан 31 арга хэмжээнд 605.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байсан.	Хугацаа болоогүй

10	Зүүнхангай сум Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 20.0 сая төгрөгийн төсөвтэй “Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн засвар үйлчилгээ” ажил, 13.0 сая төгрөгийн төсөвтэй “Хурдан морины сэрвээ хэмжих багаж тоног төхөөрөмж худалдан авах” бараа, 15.0 сая төгрөгийн төсөвтэй “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хатуу эдлэл солих” бараа, 7.0 сая төгрөгийн төсөвтэй “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл шинэчлэх” бараа, 5.0 сая төгрөгийн төсөвтэй “Ерөнхий боловсролын сургуулийн технологийн кабинетын тоног төхөөрөмж худалдан авах” бараа, 7.2 сая төгрөгийн төсөвтэй “Хөдөөгийн 3 багийн эмчид мотоцикл худалдан авах” бараа, 8.0 сая төгрөгийн төсөвтэй “Эрүүл мэндийн төвийн модон цонхыг вакуум цонхоор солих” бараа, 6.0 сая төгрөгийн төсөвтэй “4 багийн засаг даргад мотоцикл худалдан авах” бараа, 35.0 сая төгрөгийн төсөвтэй “Наадмын талбай руу цахилгааны шугам татах, холболт хийх” ажил, нийт 116.2 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 18/1 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлуулан санхүүжүүлсэн байсан.	Хугацаа болоогүй
11	Давст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 15/01 дүгээр тогтоолоор Хандгайт багийн бог малын тарилгын хашаа авах төсөл, арга хэмжээг баталж, 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр 2.2 сая төгрөг, 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 5.2 сая төгрөг, нийт 7.5 сая төгрөгийг “Хүдэнгийн сүрэг” ХХК-д шилжүүлсэн боловч Давст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 18/01 тогтоолоор тодотгол хийхдээ уг ажлыг хасч баталсан байсан.	Хугацаа болоогүй
Зөвлөмж		
12	Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 15 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 6 мөнгөн гүйлгээ, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, төсөв, хөрөнгө зарцуулах 13 шийдвэрийг байршуулаагүй байсан.	100%
13	Зүүнговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3 мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, төсөв, хөрөнгө зарцуулах 8 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байсан.	100%
14	Ховд сум тайлант онд хийж дуусгахаар гэрээ байгуулсан “Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн дотно тохижилт”-ын 70.0 сая төгрөгийн арга хэмжээ, “Дунд хэвийн худаг сэргээн засварлах” 10.0 сая төгрөгийн арга хэмжээ, нийт 80.0 сая төгрөгийн 2 ажлыг гэрээний хугацаандаа хийж дуусгаагүй байсан.	100%
15	Тэс сум цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 91.1 сая төгрөгийн зарлагын 9 мөнгөн гүйлгээг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 201.1 сая төгрөгийн орлогын 7 мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байсан.	100%
16	Давст сум цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12.9 сая төгрөгийн орлогын 1 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 111.0 сая төгрөгийн зарлагын 6 мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 126.8 сая төгрөгийн 13 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байсан.	100%
17	Тариалан сум тайлант онд хийж дуусгахаар гэрээ байгуулсан 31.1 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “Бахархал хүндэтгэл”-ийн талбайд засвар, тохижилт хийх, 35.0 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх зардал”, 15.0 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “ЭМТ-д граж шинээр барих”, нийт 81.1 сая төгрөгийн 3 ажлыг гэрээний хугацаанд хийж дуусгаагүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсан.	100%
18	Наранбулаг сум цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39.4 сая төгрөгийн орлогын 5 мөнгөн гүйлгээ хугацаа хоцроон байршуулсан, 15 сая төгрөгийн орлогын 2 мөнгөн гүйлгээ байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 823.4 сая төгрөгийн зарлагын 49 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 852.1 сая төгрөгийн 72 шийдвэрийг хугацаа хоцроон байршуулсан, худалдан авах	Хугацаа болоогүй

ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байсан.	
--	--

Эх сурвалж: ТАГ-ын Бүртгэл мэдээний маягт, аймаг сумдын ОНХС-ийн нэгтгэсэн судалгаа

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнасан боловч зарим төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй, удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим хуудаст бүрэн мэдээлээгүй байна.

3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.2-д “Сум дүүргийн ЗДТГ-ын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана”, журмын 9.9-д “Аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана” Үүнд:

- 9.9.1.ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр;
- 9.9.2.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр;
- 9.9.3.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа;
- 9.9.4.Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн гэрэл зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;
- 9.9.5.Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;
- 9.9.6.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;
- 9.9.7.Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга.

Дээрх заалтын дагуу Увс аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 1/407 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Мөн журмын 9.11-т “ОНХС-ийн орлого, зарлага нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг тухайн аймаг, нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэнэ” гэж заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнасан байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 649.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.3.2 дахь заалтад “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг

нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 649.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ДДТ2-оос Саруул өргөө, 48 айлын байр хүртэлх дулааны шугамын өргөтгөл шинэчлэл /Улаангом сум 3-р баг/ 415.1 сая, Музейн барилгын их засвар, тохижилт /Өндөрхангай сум/ 79.2 сая, Соёлын төвийн дээврийн засвар /Тариалан сум/ 69.9 сая, нийт 564.2 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ,
- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авсан 10.0 сая төгрөгийн гэр,
- Хяргас сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 33.8 сая төгрөгийн өртөгтэй "Соёлын төвийн барилгын бүрэн засварын зураг төсөв",
- Түргэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Баяр наадмын талбайн зураг 10.0 сая, чөлөөт амралтын бүсийн зураг 7.0 сая, мал угаалгын ванн зураг 5.0 сая, 3 км замын далангийн зураг 19.0 сая, нийт 41.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Дээрх аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 649.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахыг зөвлөмж болгов.

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар бүрэн хэрэгжүүлээгүй ажлыг гүйцэтгүүлж нягтлан бодох бүртгэлд тусгах зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- Тайлант онд хийж дуусгахаар гэрээ байгуулсан 31.1 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий "Бахархал хүндэтгэл"-ийн талбайд засвар, тохижилт хийх, 35.0 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх зардал", 15.0 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий "ЭМТ-д граж шинээр барих", нийт 81.1 сая төгрөгийн 3 ажлыг гэрээний хугацаанд хийж дуусгаагүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсанд.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системд 9 сум 204 төсөл, арга хэмжээний мэдээлэл дутуу оруулсан, аймгийн ОНХС болон 5 сум 41 төсөл, арга хэмжээний мэдээллийг огт оруулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “ил тод байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

- 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;
- 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

- 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
- 6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
- 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;
- 6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаа дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх гэж заасан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 10.2-д “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ” гэж заасан байна. Үүнд:

- 10.2.1.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;
- 10.2.2.ОНХС-аас аймаг, нийслэлд шилжүүлэх орлогын шилжүүлгийн сар, улирлын батлагдсан хуваарийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;
- 10.2.3.Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан баталсан сар, улирлын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;
- 10.2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж нь ОНХС-ийн орлогын шилжүүлгийг Төв төрийн сангийн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ гарсны дараа ажлын 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн ОНХС-ийн дансанд шилжүүлж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ;
- 10.2.5.Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын 2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүрэгтээ хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ.

Аудитын явцад Сангийн яамны ОНХС-ийн мэдээллийн <https://onhs.mof.gov.mn/> цахим системд оруулсан мэдээллийг хянаж үзэхэд Завхан, Зүүнговь, Наранбулаг, Өлгий, Түргэн сумууд мэдээллийг огт оруулаагүй, Баруунтуруун, Бөхмөрөн, Давст, Завхан, Малчин, Наранбулаг, Сагил, Тэс, Хяргас сумууд мэдээллийг дутуу оруулсан байна.

Хүснэгт 26. Аймаг, сумдын ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийн мэдээлэл

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Үүнээс:					
				ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг					
				Бүрэн оруулсан ТАХ-ний		Дутуу оруулсан ТАХ-ний		Огт оруулаагүй ТАХ-ний	
		Тоо	Төсөвт өртгийн дүн	Тоо	Төсөвт өртгийн дүн	Тоо	Төсөвт өртгийн дүн	Тоо	Төсөвт өртгийн дүн
0	1	2	3	4	5	6	7	8	9
1	Баруунтуруун	23	319.8			23	319.8		
2	Бөхмөрөн	33	745.6			33	745.6		
3	Давст	18	481.5			18	481.5		
4	Завхан	23	569.6	13	357.2	1	2.0	9	210.4
5	Зүүнговь	21	521.3	18	403.3			3	118.0
6	Зүүнхангай	22	365.9	22	365.9				
7	Малчин	34	480.5	18	209.4	16	271.1		
8	Наранбулаг	60	1,677.8	6	84.0	45	1,333.0	9	260.8
9	Өлгий	16	255.3	15	251.9			1	3.4
10	Өмнөговь	40	577.6	40	577.6				
11	Өндөрхангай	15	613.4	15	613.4				

12	Сагил	22	393.0			22	393.0		
13	Тариалан	31	758.5	31	758.5				
14	Түргэн	18	478.3					18	478.3
15	Тэс	26	565.6			26	565.6		
16	Ховд	21	417.5	21	417.5				
17	Хяргас	25	466.8	5	109.8	20	357.0		
18	Цагаанхайрхан	30	441.7	30	441.7				
19	Улаангом	48	1,056.1	48	1,056.1				
	Сумын дүн	526	11,185.6	280	5,630.6	204	4,468.6	40	1,070.9
	Аймгийн ОНХС	42	7,593.5	41	7,259.4			1	334.1
	Нийт дүн	568	18,779.2	321	12,889.9	204	4,468.6	41	1,405.0

Эх сурвалж: Сумдын судалгаа, Сангийн яамны цахим систем

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 10.2-д “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ”, 10.2.1-д “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна”, 10.2.3-д “Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан баталсан сар, улирлын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна”, 10.2.5-д “Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын 2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүрэгтээ хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ”, 10.3-д “Тухайн орон нутгийн төрийн сангийн төлбөр тооцоо, зарлага хариуцсан мэргэжилтэн нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ ОНХС-ийн УМС-ийг дараах байдлаар ашиглана” гэж заасан байхад аймаг, сумдын ОНХС-ийн УМС-д 9 сумын 4,468.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 204 төсөл, арга хэмжээний мэдээлэл дутуу оруулсан, аймгийн ОНХС болон 5 сумын 1,405.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41 төсөл, арга хэмжээний мэдээллийг огт оруулаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд журамд заагдсан мэдээллийг бүрэн оруулж, ашиглалтыг сайжруулж ажиллах зөвлөмж өглөө.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Бөхмөрөн, Завхан сум хугацаандаа мэдээлэл байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.3 дахь заалтад “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг зөрчин Бөхмөрөн, Завхан сум шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ. Үүнд:

- Завхан сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудаст Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 57.2 сая

төгрөгийн 2 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 336.7 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 357.2 сая төгрөгийн 18 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 360.5 сая төгрөгийн 15 шийдвэр,

- Бөхмөрөн сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудаст Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 102.4 сая төгрөгийн 2 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 693.5 сая төгрөгийн 15 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 207.9 сая төгрөгийн 14 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 508.3 сая төгрөгийн 43 шийдвэрийг тус тус байршуулаагүй байна.

Цаашид Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь оруулж ажиллах зөвлөмж өглөө.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2024 оны жил эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй, аймгийн ОНХС, Өлгий, Малчин сумын зөрчилд албан шаардлага өгсөн байна. Үүнд:

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан төсөв, хөрөнгө зарцуулах 6,253.1 сая төгрөгийн 52 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн 8 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан,
- Өлгий сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудаст Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17.5 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 101.8 сая төгрөгийн 7 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 173.5 сая төгрөгийн 13 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус байршуулаагүй байна. Мөн 25 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан,
- Малчин сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 22.0 сая төгрөгийн 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 19.2 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 7.7 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус байршуулаагүй байна.

Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2024 оны жил эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Сагил, Зүүнговь, Наранбулаг, Тэс, Давст сумд Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй байсанд зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- Сагил сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 15 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 6 мөнгөн гүйлгээ, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, төсөв, хөрөнгө зарцуулах 13 шийдвэрийг байршуулаагүй,
- Зүүнговь сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3 мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, төсөв, хөрөнгө зарцуулах 8 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй,
- Наранбулаг сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39.4 сая төгрөгийн орлогын 5 мөнгөн гүйлгээ хугацаа хоцроон байршуулсан, 15 сая төгрөгийн орлогын 2 мөнгөн гүйлгээ байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 823.4 сая төгрөгийн зарлагын 49 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 852.1 сая төгрөгийн 72 шийдвэрийг хугацаа хоцроон байршуулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй,
- Тэс сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 91.1 сая төгрөгийн зарлагын 9 мөнгөн гүйлгээг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 201.1 сая төгрөгийн орлогын 7 мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй,
- Давст сум: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12.9 сая төгрөгийн орлогын 1 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 111.0 сая төгрөгийн зарлагын 6 мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 126.8 сая төгрөгийн 13 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст тус тус байршуулаагүй байсан.

Бусад сумдын хувьд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээтэй холбогдох мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр мэдээлсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.
2. Малчин, Өлгий сум иргэдээс санал аваагүй 29 төсөл, арга хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.
3. Сумын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт уялдаагүй нийт 31 төсөл, арга хэмжээг Наранбулаг, Малчин, Бөхмөрөн сум иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.
4. Өндөрхангай сум 2 төсөл, арга хэмжээнд 14.0 сая, Цагаанхайрхан сум 1 төсөл, арга хэмжээнд 5.9 сая, Тэс сум 1 төсөл, арга хэмжээнд 4.8 сая төгрөгийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахгүйгээр зарцуулсан байна.
5. Аймгийн Засаг даргын 2024 оны А/831 дүгээр захирамжаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 289.3 сая төгрөгийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.
6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 21/01 дүгээр тогтоолоор Зураг төсөв, геологи судалгааны зардалд 334.1 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 139.9 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.
7. Наранбулаг сум 7.6 сая, Малчин сум 8.1 сая төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.
8. Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2,510.0 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 41 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байна.
9. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийгээгүй байна.
10. Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 649.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
11. Удирдлагын мэдээллийн системд 9 сум 204 төсөл, арга хэмжээний мэдээлэл дутуу оруулсан, аймгийн ОНХС болон 5 сум 41 төсөл, арга хэмжээний мэдээллийг огт оруулаагүй байна.
12. Бөхмөрөн, Завхан сум Шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулаагүй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



УВС АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

З дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2012, Факс: 7045-4095

Цахим шуудан: info@uvs.gov.mn

Цахим хуудас: www.uvs.gov.mn

2025. 06. 30 № 3 / 1158

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд тусгуулах саналгүй байна.



ДАРГА

У.ГАНЗОРИГ

8525021201



УВС АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2828

Цахим шуудан: uvs.onug@gmail.com

Цахим хуудас: www.uvs.gov.mn/onug

2025.06.30 № 120
танай _____-ны № _____-т

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд оруулах
саналгүй байна.

ДАРГА

М.УЛААНХҮҮ



85250/01.6

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн үр нөлөө сэдэвт аудитын тайлангийн төсөлд:

Аймгийн ЗДТГ-ын 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 3/1158 дугаар албан бичгээр “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа Тайланд тусгах санал байхгүй болно”,

Орон нутгийн өмчийн газар 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 12 дугаар албан бичгээр “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн үр нөлөө гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд оруулах саналгүй байна”, гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.1-д заасныг мөрдөж ажиллах.
2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсвийг хэтрүүлэн зарцуулахгүй байх.

Аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нарт:

1. Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэх.

Орон нутгийн өмчийн газар, Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Түргэн, Хяргас сумын Засаг дарга нарт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 649.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргад:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

Сумдын Засаг дарга нарт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд журамд заагдсан мэдээллийг бүрэн оруулах.

Бөхмөрөн, Наранбулаг, Малчин сумдын Засаг дарга нарт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт уялдуулан төлөвлөж батлуулах.

Наранбулаг, Малчин сумдын Засаг даргад:

1. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх.


Бөхмөрөн, Завхан сумын Засаг дарга нарт:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт уламжлах санал:

1. Аймаг суманд олгохоор төлөвлөсөн санхүүжилт Сангийн яамнаас 522.8 сая төгрөгөөр дутуу ирснээс шалтгаалан сум бүрд тодорхой хэмжээгээр бууруулан хуваарилж олгосон байна. Тухайн жилийн Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар холбогдох албан тушаалтанд чиглэл хүргүүлэхийг нэгдсэн тайланд тусгах.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР		М.БАТ-АМГАЛАН
ТАЙЛАН БИЧСЭН:		
АХЛАХ АУДИТОР АУДИТОР		Б.АВИРМЭД Р.АЮУШ Б.ОДГЭРЭЛ Т.БАТСҮХ

Увс аймаг, Улаангом-85160,
Засаг даргын тамгын газрын байр Утас:70453317
И-мэйл: uvs@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn